

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА-ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
(2016 оны жилийн эцэс)

НЭГ. НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

<i>Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</i>	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	<i>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</i>	Үнэлгээ (0-30 оноо)	УУХҮЯ-НЫ ХШҮДА Г-ЫН ҮНЭЛГЭЭ
1	2	3	4	5
Нэг. “Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээний хүрээнд:				
1.2. Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах				
1.2.1. Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн төслийг нэгтгэн боловсруулж, УУХҮ-ийн сайдаар батлуулах	- Батлагдсан загвар, хуульд нийцсэн байх - 9-р сард - 1 баримт бичиг	Байгууллагын стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн төслийг боловсруулан 2016 оны 10-р сард албан бичгээр УУХҮЯ-нд хүргүүлэн санал авсан бөгөөд ирүүлсэн санал, нэмэлт засваруудыг оруулан дахин УУХҮЯ-ны Хуулийн хэлтэст хүргүүлэн батлуулсан.		
1.2.2. Ашигт малтмал, газрын тосны газрын дарга-Төсвийн шууд захирагчийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай байгуулах 2016 оны үр дүнгийн гэрээг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах. Нэгжийн менежерүүд болон төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ байгуулах, ёсчлох ажилд арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллах	- Газрын үйл ажиллагааг бүхэлд нь хамарч чадсан байна. - 8-10 сард - 1 гэрээ, 1 ажил үйлчилгээ	- Байгууллагын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдсэнтэй холбогдуулан АМГТГ-ын даргын УУХҮ-ийн сайдтай байгуулах үр дүнгийн гэрээний төслийг нэгтгэн боловсруулж, санал авахаар 2016.10.12-ны 9/957 тоот албан бичгээр УУХҮЯ-ны ТЗУГ-т хүргүүлсэн. - Гэрээний төсөлд УУХҮЯ-наас ирүүлсэн саналыг тусгаж, засварлан 2016.10.28-ны өдрийн 1/1321 тоот албан бичгээр УУХҮЯ-ны ТЗУГ-ын даргад хүргүүлэн сайдад танилцуулсан. Гэрээ батлагдсаны дагуу менежер, төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээг байгуулан ажилласан.		
1.2.3. Батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулах, батлуулан мөрдүүлэх ажлыг зохион байгуулах	- Хууль журамд нийцсэн байна - 9-10 сард - 1 ажил үйлчилгээ	Батлагдсан орон тооны дагуу нийт ажлын байрны тодорхойлолтод тухайн албан тушаалын ажлыг тодорхой зааж, ажлын давхардлыг арилган, ажлын ачааллыг жигдрүүлэн нарийвчлан боловсруулж, удирдлагад танилцуулан батлуулсан.		
1.2.4. Томилогдсон ажилтан албан хаагчдын ажилласан жил, ур чадварыг харгалзан үндсэн болон нэмэгдэл цалингийн хэмжээг шинэчлэн, даргын	- Хуульд нийцүүлсэн байна - III улиралд - 1 ажил үйлчилгээ	Байгууллагын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдсэнтэй холбогдуулан нийт албан хаагчдын цалин, ур чадвар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг хууль журамд нийцүүлэн боловсруулж, тушаалын төслийн хамт удирдлагад танилцуулж,		

тушаалаар батлуулан мөрдүүлэх		батлуулан мөрдүүлсэн. Хүний нөөцтэй холбогдолтой нийт 138 тушаалын төсөл боловсруулан, батлуулсан байна.	
1.2.5. 2016-2017 оны хичээлийн жилд тус газартай гэрээ байгуулан гадаадын их дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудын асуудлыг зохицуулах, агентлагийн 2016 оны сургалтын төлөвлөгөөний дагуу ажилтнуудын мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх сургалт, давтан сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах	- Үр дүнтэй, шуурхай зохион байгуулна - Тогтмол - 70 оюутан,	- Тус газартай “Урт хугацааны сургалтын гэрээ” байгуулан 2015-2016 оны хичээлийн жилд гадаадын их дээд сургуульд суралцсан 88 оюутнаас 20 оюутан сургуулиа төгсөж, шинээр 8 оюутан сургалтын гэрээ байгуулан, өнөөдрийн байдлаар 71 оюутан гадаадын их дээд сургуульд суралцаж байна. Эдгээр суралцагсдын 29 оюутны сургалтын төлбөрийн тодорхой хувийг шийдвэрлэсэн. - “АМГТГ-ын ажиллагсдын сургалтын журам” болон “Урт хугацааны сургалтын гэрээ”-ний загваруудыг шинэчлэн боловсруулж батлуулахад бэлтгэсэн. УУХҮЯ-наас санал авахаар хүргүүлээд байна. - Удирдлагын Академийн Мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран зохион байгуулж буй байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан “Байгууллагын менежментийн хөгжлийн чиг хандлага” сэдэвт 68 цагийн багц сургалтыг зохион байгуулж байна. - 2016 оны сүүлийн хагас жилд дотоодын магистрт 1 ажилтан, Японы ЖАЙКА, БНСУ-ын КОЙКА-ийн сургалтад тус бүр 1 ажилтан, БНСУ-ын КИГАМ-ын сургалтад 2 мэргэжилтэнг хамруулсан. - 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Архивын ерөнхий газрын Мэргэжил, аргазүйн газрын дарга Ц.Цэндсүрэнг урин ирүүлж “Албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалт” сэдвээр нийт ажилтан, албан хаагчдын дунд сургалт зохион байгуулав.	
1.2.6. Байгууллагын веб сайтыг шинэчлэх, хэвийн тасралтгүй ажиллагааг хангах, шаардлагатай мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэх	- Хэрэгцээтэй мэдээллийг шуурхай хүргэсэн байна - Тогтмол - 2 ажил үйлчилгээ	Байгууллагын болон кадастрын веб сайтын хэвийн үйл ажиллагааг хангаж шаардлагатай мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь тогтмол шинэчилж ажилласан. Нийт 186 мэдээ байршуулсан байна. Байгууллагын веб сайтын загвар дизайныг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн, мэргэжлийн компанитай хамтран динамик төвшний веб хуудсыг сайжруулан хийхээр ажиллаж байна. Байгууллагын болон салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тогтмол оруулан ажилласан. Байгууллагын веб хуудасны шинэчилсэн хувилбарыг туршилтын журмаар www.mrpm.gov.mn/mrpm/ хаягаар ажиллуулж байна.	
1.2.7. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг тогтмол, шуурхай эрхлэн	- Заавар журмын дагуу шуурхай, тасралтгүй	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг тогтмол, шуурхай эрхлэн явуулах, ажилтан, албан хаагчдад архив, албан хэрэг	

<p>явуулах, ажилтан, албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын талаар аргазүйн зөвлөгөө өгч ажиллах</p>	<p>- Тогтмол - 2 ажил үйлчилгээ</p>	<p>хөтлөлтийн ажлын талаар аргазүйн зөвлөгөө өгөх ажлыг удирдан зохион байгуулж ажилласан. - 2016 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны хооронд нийт 3260 албан бичгийг зохих журмын дагуу хүлээн авч бүртгэсэн ба нийт 2165 албан бичгийн стандартад хяналт тавин дугаар өгч гадагш илгээсэн байна. - Тайлант хугацаанд нийт 171 өргөдлийг зохих журмын дагуу хүлээн авч, цахим бүртгэлд бүртгэж, хяналтын карт хөтлөн, холбогдох албан тушаалтанд танилцуулж, хариуг цахим бүртгэлд бүртгэн хаасан байна.</p>	
<p>1.3. Байгууллагын болон салбарын төвшинд гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах</p>			
<p>1.3.1. Геологи, уул уурхай, газрын тосны салбарт хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэх боломжтой төслүүдийн ажлыг нэгтгэн зохион байгуулж, бүтцийн холбогдох нэгжүүдтэй хамтран ажиллах</p>	<p>- Төсөл, хөтөлбөр хэрэгжих таатай нөхцлийг бүрдүүлж ажиллана - Тухай бүр - хэрэгжих төслийн тоогоор</p>	<p>Салбарын чиглэлээр хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэх боломжтой төслүүдийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиглэлээр нэгжүүдтэй тогтмол хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд ХБНГУ-ын Холбооны Геошинжлэх ухаан, Байгалийн нөөцийн хүрээлэн /BGR/-тэй хамтран “АМГ-ын чадавхийг бэхжүүлэх” төсөл, БНСУ-ын Геошинжлэх ухаан эрдэс баялгийн хүрээлэнтэй хамтран 1:50 000-ны судалгаа, олон улсын хамтарсан 3D төсөл зэрэг төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Үүнд: - ХБНГУ-ын Холбооны Геошинжлэх ухаан, Байгалийн нөөцийн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын Ашигт малтмалын газрын эрдэс баялгийн эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх” төслийн 1-р үе шат энэ оны 12-р сард хэрэгжээд дуусч байна. Уг төслийн хүрээнд уулын ажлын төлөвлөгөө, тайлангийн онлайн систем буюу e-reporting, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өргөдлийн онлайн систем нэвтрүүлэх зэрэг ажил хийгдэж байна. - БНСУ-ын Геологийн шинжлэх ухаан, эрдэс баялгийн хүрээлэн /КИГАМ/-тэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол орны өмнөд хэсэгт геологийн судалгаа болон ашигт малтмалын хайгуул хийх” төслийн хээрийн судалгааны ажлын эхний үе шат хийгдэж дуусаад, БНСУ-ын талаас ирж хээрийн судалгаанд оролцсон геологичид буцсан. - БНУУ-ын Худалдааны төлөөлөгчийн газартай 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Монголын уул уурхайн салбарт хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурах ёслолын арга хэмжээг зохион</p>	

		<p>байгууллаа.</p> <ul style="list-style-type: none"> - Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газрын харьяа Геологи, эрдэс баялгийн агентлаг, АМГ /хуучин нэрээр/ хоорондын хамтын ажиллагааны Санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагааг зохион байгуулав. - АМГ-ын /хуучин нэрээр/ мэдээлэл технологийн салбарын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх, Эрдэс баялгийн нэгдсэн мэдээллийн санг бий болгоход чиглэгдсэн програм хангамжийн мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх зорилгоор “Клейр Корп” ХХК-тай хамтран ажиллах тухай Санамж бичиг байгуулагдсан. 	
<p>1.3.2. Гадаадын зочид, төлөөлөгчидтэй хийх уулзалт, ярилцлагын бэлтгэлийг ханган зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, орчуулга хийж ажиллах</p>	<ul style="list-style-type: none"> - Шуурхай, өндөр хэмжээнд зохион байгуулсан байна - Тухай бүр - 1 ажил үйлчилгээ 	<p>Гадаадын зочид, төлөөлөгчидтэй хийх уулзалт, ярилцлагын бэлтгэлийг тухай бүр ханган зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн оролцож ажилласан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - ХБНГУ-ын Холбооны Геошинжлэх ухаан, Байгалийн нөөцийн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын Ашигт малтмалын газрын эрдэс баялгийн эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх” төслийн багийн төлөөлөгчидтэй газрын даргын хийх уулзалтыг зохион байгуулав. - БНСУ-ын Газрын тосны газар (K-Petro)-ын Дэд дарга болон холбогдох албан тушаалтнууд 2016 оны 11-р сард хүрэлцэн ирж, АМГТГ-ын удирдлагуудтай уулзах уулзалтын бэлтгэлийг ханган зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцсэн. - Франц Улсын Элчин сайд XI/02-ны өдөр тус газарт хүрэлцэн ирж, агентлагийн удирдлагуудтай хийсэн уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтын үеэр цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолт, байгаль орчны аюулгүй байдлын чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцсон. 	
<p>1.3.4. Байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцах, үйлчлүүлэгчдэд лавлагаа мэдээлэл өгөх</p>	<ul style="list-style-type: none"> - Газрын үйл ажиллагааны талаар нийгэмд эерэг ойлголтыг өгөх - Тогтмол - 2 ажил үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> - Газрын тосны салбарын хэмжээн дэх мэдээ мэдээлэл болон байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд түгээн сурталчлах “Газрын тосны салбар-2016” нэгдсэн төлөвлөгөө боловсруулан олон нийтэд мэдээлэн сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулж ажилласан. Төлөвлөгөөний дагуу газрын тосны салбарын үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв үйл ажиллагааны үр дүнг МҮОНРТ, Eagle, UBS, TV-5, MNC, Bloomberg, NTV, TM, TV-25 дугаар суваг орон нутгийн телевиз болон 3 вэб сайт, 6 өдөр тутмын сонин, 1 радиогоор дамжуулан хэвлэлийн 120 мэдээ 	

		<p>бэлтгэн олон нийтэд хүргэсэн.</p> <p>- Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдэд нийтлэгдсэн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон салбарын хэмжээн дэх цаг үеийн мэдээ, мэдээллийг удирдлагад тухай бүр шуурхай танилцуулж, шаардлагатай тохиолдолд тэдгээрт тайлбар, тодруулга, залруулга бичиж хянуулах, нийтлүүлэх, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан.</p> <p>Нийтлэгдсэн мэдээ, мэдээллийг агуулгаар нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Газрын тосны газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл-38 ▪ Газрын тосны хайгуул, олборлолттой холбоотой мэдээлэл-36 ▪ Газрын тосны бүтээгдэхүүн хангамжтай холбоотой мэдээлэл-160 ▪ Газрын тос боловсруулах үйлдвэртэй холбоотой мэдээлэл-4 ▪ Газрын тосны газраас олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр нийтлүүлсэн, нэвтрүүлсэн мэдээлэл нийт 120 гарсан байна. ▪ Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахтай холбоотой мэдээлэл - 19 ▪ 9 дүгээр сараас хойш нүүрстэй холбоотой мэдээлэл-146 ▪ Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл - 26 <p>ОНМХ-д нийтлэгдсэн мэдээ, мэдээллийн 16%-ийг ГТГ-ны үйл ажиллагаатай холбоотой, 18,6% нь газрын тосны олборлолттой холбоотой, газрын тосны бүтээгдэхүүний хангамж үнэ болон нүүрсний үнэтэй холбоотой мэдээлэл 51,4%-ийг, үлдсэн 20%-ийг бусад мэдээлэл эзэлж байна. Өдөр тутам ХМХ-д тавигдсан салбарын талаарх мэдээлэлд мониторинг хийж байна.</p>	
<p>1.4. Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулах, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг зохион байгуулах</p>			
<p>1.4.1. Улсын төсөвт нийт 160,2 тэрбум төгрөг төвлөрүүлэхэд хяналт тавих, орлогыг бүртгэх, биелэлтийг тайлагнах ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах</p>	<p>- Орлогыг тухай бүр төвлөрүүлсэн байна - I-IV улиралд - Төсөвт төвлөрүүлсэн үр дүнгээр</p>	<p>2016 онд улсын төсөвт нийт 160.25 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 11-р сарын 30-ны өдрийн байдлаар нийт 162.63 тэрбум төгрөг төвлөрүүлж, гүйцэтгэл 101.5 хувьтай болж, орлогын төлөвлөгөөг 1.5 хувиар давуулан биелүүлээд байна.</p> <p>Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 32.68 тэрбум төгрөг, - Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр 1.47 тэрбум төгрөг, 	

		<ul style="list-style-type: none"> - Газрын тосны экспортын орлого 107.87 тэрбум төгрөг, - Бусад орлого 20.58 тэрбум төгрөг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн. 	
1.4.2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	<ul style="list-style-type: none"> - Мэдээлэл олон нийтэд хүрсэн байна - I-IV улиралд - 1 ажил үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> - Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого зарлагын гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагуудтай хийсэн гэрээ болон бусад холбогдох мэдээллийг тогтмол байршуулан ажилласан. - Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. - Үндэсний аудитын газраас Уул уурхайн сайдын багцын хүрээнд, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын шалгалтад хамрагдаж Зөрчилгүй сайн гэсэн дүгнэлт авсан. 	
1.4.3. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, журмын дагуу хөтөлж, санхүүгийн тайлан балансыг хуулийн хугацаанд гарган, УУХҮЯ, Сангийн яаманд тушаах	<ul style="list-style-type: none"> - Санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг үнэн зөв, бодитой тайлагнасан байна - Улирал бүр - 1 тайлан баланс 	<ul style="list-style-type: none"> - 2015 оны жилийн эцсийн тайлан балансыг гарган, Үндэсний Аудитын газраар хянуулан, тайланг баталгаажуулан УУХҮЯ, СЯ-нд хуулийн хугацаанд хүргүүлэн Аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу ажилласан. - 2015 оны жилийн эцсийн, 2016 оны 1-11 сарын, 1-3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлан, худалдан авалтын тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хугацаанд нь гаргаж УУХҮЯ-нд хүргүүлэн, удирдлагыг мэдээллээр ханган ажиллав. - 2 агентлагийг нэгтгэснээр 2016 оны 7 дугаар сарын 31-ний өдрөөр хаалтын санхүүгийн тайлан, 8 дугаар сарын 1-ний өдрөөр нээлтийн балансыг гаргаж, УУХҮЯ-нд хүргүүлсэн. 2 агентлагийн хаалтын баланс, санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас санхүүгийн шалгалт хийгдэж байна. - 2017 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь, худалдан авалтын төлөвлөгөөг хуулийн хугацаанд тооцоолон хийж, УУХҮЯ-нд хүргүүлсэн. 	
1.4.4. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, автомашины албан татвар, даатгалын тооцоог холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах ажлыг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Хуулийн дагуу, өр авлага үүсгэхгүй ажиллана - Сар бүр - 1 ажил үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татвар, автомашины албан татварын тооцоог холбогдох байгууллагатай хийж автомашины болон жолоочийн хариуцлагын даатгал, эд хөрөнгийн даатгал, гэнэтийн ослын даатгал зэргийг даатгалын компанитай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. - 2015 оны Нийгмийн даатгал, татварын тайлангуудыг гарган 	

		<p>баталгаажуулж, хуулийн хугацаанд багтаан тушаасан.</p> <p>- Харилцаа холбоо, цахилгаан, дулаан, харуул хамгаалалтын байгууллагууд болон бусад харилцагч байгууллагуудтай аж ахуйн гэрээг сунгах шаардлагатай тохиолдолд шинэчлэн, холбогдох тооцоог тухай бүр хийж, өр авлага үүсгэхгүй байхад анхаарч ажилласан.</p>	
1.4.5. Байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийж бүртгэх, актлах, данснаас хасах үндсэн хөрөнгийн жагсаалтыг гаргаж, холбогдох газруудад хүргүүлэн шийдвэрлүүлэхэд бэлтгэх	<p>- Алдаа мадаггүй, шуурхай зохион байгуулан ажиллана</p> <p>- Жилийн эцэст</p> <p>- 1 ажил үйлчилгээ</p>	<p>- 2015 оны жилийн эцсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг 2016 оны 1 дүгээр сарын 20-ны өдөрт багтаан хийж дуусгасан.</p> <p>- АМГТГ-ын даргын 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А-41 дүгээр тушаалаар 2016 оны үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийх ажлын хэсгийг батлуулсан бөгөөд тооллогын ажлыг хийж гүйцэтгэж байна.</p>	
1.5. Газрын тосны салбарын хөрөнгө оруулалтыг бодитой тооцож, хяналт тавих, газрын тостой холбоотой үйл ажиллагаанаас орох орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах			
1.5.1. Гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардлын тайланг улирал бүр гаргуулан авч судлах, нэгтгэн дүгнэлт гаргах	<p>- Хуулийн дагуу үнэн зөв, бодитой тооцож, дүгнэлт гаргана</p> <p>- III, IV улиралд</p> <p>- Гэрээлэгчдийн тоогоор</p>	<p>- БХГ-т нийт 23 талбайгаас хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар 2016 оны төлөвлөгөө, төсвөө ирүүлсэн 12 гэрээт талбайн нийт 485.25 сая ам долларын төсвийг холбогдох хэлтсүүдтэй хамтран батлуулсан ба үйл ажиллагааны зардлын задаргаанд хяналт тавьж, тооцоо хийн, санал дүгнэлтээ гаргасан. (бусад БХГ-ийн хувьд мораториум авсан болон төлөвлөгөө, төсөв ирүүлээгүй, үйл ажиллагаа явуулаагүй, гэрээ цуцлагдсан зэрэг болно)</p> <p>- Гэрээлэгчдийн 2015 оны жилийн эцэс болон 2016 оны 1-3 дугаар улиралд хийгдсэн ажил, зарцуулсан хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардлын тайлангуудыг улирал бүр гаргуулан хүлээн авч нэгтгэсэн. 2016 оны 1-3 дугаар улирлын тайлангаар хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардлын хэмжээ I улиралд 14.6 сая ам.доллар, II улиралд 17.6 сая ам.доллар, III улиралд 18.3 сая ам.доллар болсон байна. Нийт хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардлын хэмжээ 2015 оны жилийн эцсийн байдлаар 396.83 сая ам.доллар, 2016 оны 3-р улирлын байдлаар 50.66 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн тайлангуудыг хүлээн авч нэгтгэсэн.</p>	
1.5.2. Гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах, Үндэсний аудитын газраас гүйцэтгэх санхүүгийн шалгалтад шаардлагатай мэдээ, тайланг гаргаж, хүргүүлнэ.	<p>- Үнэн зөв, бодитой мэдээллээр шуурхай хангаж ажиллана</p> <p>- Тухай бүр</p> <p>- Шаардлагатай тоо</p>	<p>- Газрын тосны тухай хуульд заасны дагуу 2014 оноос эхлэн Үндэсний аудитын газартай хамтран гэрээлэгч компаниудын хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах ажлыг хийх болсонтой холбогдуулан санхүүгийн шалгалтын ажлыг хэрхэн явуулах талаар хамтран ажиллах санамж бичгийг 2 талын</p>	

	хэмжээгээр	<p>удирдлагаар батлуулан мөрдөж ажиллаж байна. Санхүүгийн шалгалтыг хамтран гүйцэтгэхтэй холбогдуулан шинэчлэн батлагдсан БХГ-ний загвар, санхүүгийн шалгалт гүйцэтгэх тухай тушаал, удирдамжийн загвар зэрэг шаардсан мэдээ, мэдээллийг тус газарт хүргүүлсэн. Мөн 2011-2013 оны хоорондох хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах ажил дуусаагүй гэрээлэгчдийн санхүүгийн шалгалтыг дуусгах ажлын хэсгийг шинээр байгуулав. Гэрээлэгчдийн 2012, 2013, 2014 онд газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах ажлын хүрээнд “Доншен газрын тос /Монгол/” ХХК, “Петроматад” ХХК, “Капкорп Монголиа” ХХК, “Монголын алт” ХХК, “Магнай Трейд” ХХК, “Импайр Газ Монголиа” ХХК, “Зон Хэн Юу Тиан” ХХК-ийн хөрөнгө оруулалт-өртөг нөхөх зардлыг хянаж баталгаажуулахаар ажиллав.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Монголын алт” ХХК-ийн 2014 оны газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт 15,3 мянган ам.доллараар 2016 оны 10 дугаар сард, - “Магнай Трейд” ХХК-ийн 2014 оны газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт 1,9 сая ам.доллараар 2016 оны 10 дугаар сард, - “Импайр Газ Монголиа” ХХК-ийн 2014 оны газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт 30,8 мянган ам.доллараар 2016 оны 10 дугаар сард, - “Петроматад” ХХК-ийн 2014 оны газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт 502,8 мянган ам.доллараар 2016 оны 10 дугаар сард, - “Капкорп Монголиа” ХХК-ийн IV талбайн 2014 оны газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт 121,3 мянган ам.доллараар 2016 оны 10 дугаар сард, - “Капкорп Монголиа” ХХК-ийн V талбайн 2014 оны газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт 126,5 мянган ам.доллараар 2016 оны 10 дугаар сард тус тус эцэслэн баталгаажуулагдаж байна. Дээр дурдсан 6 гэрээлэгч 2014 онд газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд нийт 2,7 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. - “Доншен газрын тос Монгол” ХХК-ийн 2014 оны газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалтад гүйцэтгэх санхүүгийн шалгалтыг ҮАГ-тай хамтран гүйцэтгэж
--	------------	--

		<p>байна.</p> <p>- “Петроматад” ХХК-ийн 2013 оны газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалтад гүйцэтгэх санхүүгийн шалгалтын холбогдох материалыг эцэслэн бэлтгэж, гэрээлэгчид хүргүүлсэн болно.</p> <p>- “Капкорп Монголиа” ХХК-ийн 2013 оны газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалтад гүйцэтгэх санхүүгийн шалгалтын холбогдох материалыг эцэслэн, гэрээлэгчид хүргүүлсэн.</p> <p>- “Вульф Петролеум” ХХК-ийн 2014 оны газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалтад гүйцэтгэх санхүүгийн шалгалтыг ҮАГ-тай хамтран гүйцэтгэсэн бөгөөд холбогдох материалыг эцэслэн бэлтгэж, гэрээлэгчид хүргүүлсэн болно.</p>	
1.5.3. Газрын тосны тухай хуулийн дагуу шинэчлэх шаардлагатай дүрэм, журмуудыг судлан, журмын төслийг боловсруулж, УУХҮЯ-нд хүргүүлэх	<p>- Батлагдах боломжтой, үндэслэл сайтай байна</p> <p>- Жилдээ</p> <p>- Шаардлагатай тоо хэмжээгээр</p>	<p>- Газрын тосны тухай хуулийн дагуу Засгийн газраар батлуулах “Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам”, “Газрын тосны бүртгэл, тооцооны журам”-уудын төслийг боловсруулж, батлуулах Уул уурхайн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж, ажиллаж байгаа болно. /журмуудын төслийн анхны хувилбарыг ажлын хэсгийн нарийн бичигт хүргүүлсэн/</p>	
1.5.4. Газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ, валютын ханшийн судалгааг тогтмол хийх	<p>- Судалгаа мэдээлэл үнэн зөв, тогтмол шинэчлэгдэж байна</p> <p>- Жилдээ</p> <p>- 1 ажил үйлчилгээ</p>	<p>Газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ, валютын ханшийн судалгааг тогтмол хийж, үнийн мэдээллийн “Платц” сайтаас авч судлан удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан.</p>	
1.5.5. Гэрээлэгчдийн борлуулсан түүхий тосны орлого, зардал, нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, Монгол Улсын Засгийн газарт ногдох тосны орлогын тайланг сар бүр хүлээн авч, нэгтгэх, хяналт тавих	<p>- Алдаа мадаггүй, үнэн зөв хянасан байна</p> <p>- Жилдээ</p> <p>- 1 ажил үйлчилгээ</p>	<p>- Гэрээлэгчийн экспортолсон түүхий тосны борлуулалтын орлого, зардлын тайланг сар бүр хүлээн авч, орлогын хуваалтын тооцоог хийж хяналт тавьж ажилласан.</p> <p>- “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн Тосон-Уул XIX талбайгаас 2016 оны 1-10 сарын экспортын дүнгээр нийт 3.13 сая баррель түүхий тос борлуулснаас Монгол Улсын Засгийн газарт ногдох тосны орлого нь нийт 19.77 сая ам.доллар, Тамсаг ХХI талбайгаас 3.08 сая баррель түүхий тос борлуулснаас Засгийн газарт ногдох орлого нь нийт 25.34 сая ам.доллар бөгөөд үүнээс 6.67 сая ам.доллар нь нөөц ашигласны төлбөр, 18.67 сая ам.доллар нь Засгийн газарт ногдох тосны орлого байна.</p> <p>- “Доншен газрын тос (Монгол)” ХХК ХХК-ийн БХГ-97 талбайгаас 2016 оны 3-р улирлын байдлаар нийт 292.42 мянган баррель</p>	

		<p>түүхий тос экспортлон борлуулснаас Монгол Улсын Засгийн газарт ногдох тосны орлого нь нийт 2.54 сая ам.доллар бөгөөд үүнээс 657.9 мянган ам.доллар нь нөөц ашигласны төлбөр, 45.62 мянган ам.доллар нь өртөг нөхөлт, 1.78 сая ам.доллар нь Засгийн газарт ногдох тосны орлого байна.</p> <p>Нийт газрын тосны экспорт, борлуулалтын орлогоос 11-р сарын 30-ны байдлаар улсын төсөвт 107.87 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.</p> <p>- Түүхий тосны дэлхийн зах зээлийн үнийн мэдээллийг сар бүр дэлхийн эрчим хүчний мэдээллийн нэгдсэн сүлжээ байгууллага болох Platts-аас тогтмол авч судалгааг хийж ажилласан.</p> <p>Дэлхийн зах зээлийн үнэтэй холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр холбогдох байгууллага, хэлтсүүдэд гарган өгч ажилласан. Тус компанитай байгуулсан мэдээлэл авах үйлчилгээний гэрээг сунгах хэлэлцээрийг хийж, төлбөрийг 2017 онд 50 орчим хувиар бууруулахаар шийдвэрлэсэн болно. 2016 оны эхний 1-11 сарын байдлаар “Петрочайна дачин Тамсаг” ХХК-ний экспортын үнийн суурь болдог “Daqing 33⁰” түүхий тосны үнэ дэлхийн зах зээл дээр дунджаар баррель тутамд 36.28 ам.доллар байсан бол “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ний экспортын үнийн суурь “DTD Brent” түүхий тосны үнэ дэлхийн зах зээл дээр дунджаар 42.79 ам.доллар байсан болно.</p>	
<p>1.5.6. Гэрээлэгчдийн Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх тусгай зөвшөөрлийн төлбөр, сургалтын урамшуулал, төлөөлөгчийн газрыг дэмжих үйл ажиллагааны төлбөрүүдийг Газрын тосны тухай хууль болон гэрээнд заасан хугацаа, талбайн хэмжээ зэргээс хамааруулан тухай бүр тооцож, нэхэмжлэх, тайлан мэдээ гаргах, гэрээлэгчидтэй тооцоо нийлж, баталгаажуулах</p>	<p>- Гэрээний хэрэгжилт хангагдаж, баталгаажсан байна</p> <p>- Жилдээ</p> <p>- 2 ажил үйлчилгээ</p>	<p>- Гэрээлэгч компаниудын БХГ-ний дагуу төлөх тусгай зөвшөөрлийн төлбөр, сургалтын урамшуулал, төлөөлөгчийн газрыг дэмжих үйл ажиллагааны төлбөрүүдийг Газрын тосны тухай хууль болон БХГ-нд заасан хугацаа, талбайн хэмжээ зэргээс хамааруулан тухай бүр тооцож, нэхэмжилсэн. 2016 онд нийт тусгай зөвшөөрлийн төлбөрт 1.3 сая ам.доллар төлөгдөхөөс 0.6 сая ам.доллар, төлөөлөгчийг дэмжих үйл ажиллагааны төлбөрт 1.24 сая ам.доллар төлөгдөхөөс 480.3 мянган ам.доллар, сургалтын урамшуулалд 1.47 сая ам.доллар төлөгдөхөөс нийт 399.9 мянган ам.доллар төлөгдсөн үзүүлэлттэй байна. Гэрээлэгчдэд 3 удаа албан тоотуудаар төлбөрийн нэхэмжлэлийг хүргүүлсэн бөгөөд төлбөр төлөлт дунджаар 50 хувьтай байгаа нь Гэрээлэгчдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, санхүүгийн чадамж буурсантай холбоотой.</p>	
<p>1.5.7. Гэрээлэгчдийн олсон орлого, төлсөн төлбөр, хураамж, хандивын тайланг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын</p>	<p>- Батлагдсан загварт нийцсэн, үнэн зөв, бодитой байна</p>	<p>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Ажлын албанд 2015 онд нийт 17 гэрээлэгчдээс төсөвт төвлөрүүлсэн 165.2 тэрбум төгрөгийн орлого, төлсөн төлбөр, хураамж, хандивын</p>	

санаачлагын Үндэсний зөвлөл, ажлын албанд хүргүүлэх	- IV улиралд - 1 тайлан	тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж хүргүүлэв. - Газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн 2015 онд төсөвт төвлөрүүлсэн төлбөр, борлуулалтын орлогыг компани тус бүрээр ҮСХ, СЯ-наас баталсан маягтын дагуу хугацаанд нь гаргаж ТЕГ, ОУИТБСА-нд мэдээлсэн. - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын албанаас зохион байгуулсан Үндэсний чуулган, хурал, ажлын уулзалтад байнга оролцож Газрын тосны тухай хууль, БХГ-ний зарчим, БХГ-ний дагуу үйл ажиллагаа явуулж буй компанийн талаар мэдээлэл өгч ажилласан.	
1.6. Улсын болон хувийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгаа, хайгуулын ажлын төсвийн гүйцэтгэл, зардлын доод хэмжээнд хяналт тавих			
1.6.1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны ажлуудын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, төслүүдийн төсвийн норм, нормативыг хянах	- Шуурхай, үнэн бодитой хянасан байна - Сар бүр - Төслүүдийн тоогоор	2016 онд улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэх төлөвлөгөө, 2015 оны үлдэгдэл санхүүжилт 2.6 тэрбум төгрөг, 2016 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө 6.7 тэрбум төгрөг буюу нийт 9.3 тэрбум төгрөгөөр батлагдсан. Нийт 38 төсөл хэрэгжүүлж 6.5 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэсэн. Энэ онд үр дүнгийн 5 тайланг, төсвийн тодотголоор 31 төслийг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Тайлангийн барьцаанд 236.2 сая төгрөг төвлөрүүлсэн. Аргачлал хяналтын зардлын дансанд 96.9 сая төгрөг төвлөрүүлсэн.	
1.6.2. Хувийн хөрөнгөөр геологи, хайгуулын ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийн зардлын доод хэмжээг хянан баталгаажуулах, тодорхойлолт олгох	- Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт хангагдана - Ирсэн тайлангийн тоогоор - Хуульд заасан хугацаанд	- Хайгуулын ажлын үр дүнгийн 9 тайланг тухай бүр хүлээн авч бүртгэн хянаж тойрох хуудсанд тэмдэглэл хийсэн. - Аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирсэн хүсэлтийн дагуу нийт 56 тодорхойлолт гаргасан. - Хугацаа хоцорч торгуулийн арга хэмжээ авагдсан буюу засварлах шаардлагатай 7 тайлан хүлээн авч бүртгэн хайгуулын ажлын зардлын доод хэмжээг хянан баталгаажуулсан.	
1.6.3. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн зардлыг хянах	- Журмын дагуу шуурхай зохион байгуулан ажиллана - Ирсэн тайлангийн тоогоор - Тухай бүр	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн зардлыг тухай бүр хянан баталгаажуулж ажилласан.	
Хоёр. “Агентлагийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон бусад гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, сурталчлах, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээний хүрээнд:			

2.1. Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй эрх зүйн актыг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах		
2.1.1. Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Цөмийн энергийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж удирдлагад танилцуулах.	<ul style="list-style-type: none"> - Үндэслэл сайтай батлагдах боломжтой байна - IV улиралд - Шаардлагатай тоо хэмжээгээр 	<p>Дараах ажлууд хийгдсэн байна:</p> <ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд АМГ/хуучнаар/-ын бүх хэлтсүүдээс саналыг авч нэгтгэн, төсөл боловсруулах Ажлын хэсэгт хүргүүлсэн. - УИХ-ын гишүүн Н.Батбаярын санаачилсан Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.19 дэх заалтыг нэмж оруулсантай холбоотойгоор уг өөрчлөлт болон Газрын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд оруулах нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгөв. - ЗГХЭГ-ын дарга, сайд С.Баярцогтоос ирүүлсэн “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаарх авах арга хэмжээний тухай” ЗГ-ын тогтоолын төсөлд санал хүргүүлэв. - Уул уурхайн сайд болон Сангийн сайдын хамтарсан тушаалын төсөлд саналыг 2016.01.06-ны өдөр УУЯ-нд хүргүүлэв. - Ашигт малтмал, газрын тосны салбарт хэрэгжиж буй хууль тогтоомжийн судалгаа, тэдгээрийн хэрэгжилтийн байдлын талаарх мэдээллийг гаргаж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.
2.1.2. Салбарын холбогдолтой хууль тогтоомж, дүрэм журмыг нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Олон нийтийг хамарсан, үр дүнтэй байх - жилдээ - 1 ажил үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> - Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүд болон Засаг дарга, холбогдох сумдын ИТХ-ын гишүүд, сумдын Засаг дарга нартай уулзалт зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааг танилцуулах, АМТХ-ийн хэрэгжилт, хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдлийн болон сонгон шалгаруулалтын талаар мэдээлэл өгөх, цаашид харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллах талаар хэлэлцсэн. - “Захиргааны ерөнхий хууль” шинээр батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан уг хуулийг нийт албан хаагч нарт сурталчлан танилцуулах, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын талаар сургалт зохион байгуулсан.
2.3. Бүтээгдэхүүн хуваах зарчмаар газрын тосны хайгуул, ашиглалтын гэрээ болон бусад гэрээ, хэлэлцээр (шинэ төсөл) хийх, гэрээлэгчийг сонгон шалгаруулахад оролцох, гэрээний хэрэгжилтийг хангуулахад хяналт тавих ажлыг зохион байгуулах		
2.3.1. Бүтээгдэхүүн хуваах зарчмаар газрын тосны хайгуул, ашиглалтын гэрээ, хэлэлцээр байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Хуулийн дагуу шуурхай зохион байгуулна - IV улирал - Байгуулагдах гэрээний тоогоор 	<ul style="list-style-type: none"> - Газрын тосны хайгуулын Эргэл XII талбайн олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж ажлын хэсэг болон үнэлгээний хэсэгт орж ажилласан. Энэхүү сонгон шалгаруулалтын ялагч “Smart oil investment LTD” ХХК-тай 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан “Газрын тосны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга, түүнийг дагаж Засгийн газрын 2015 оны 3 дугаар

		<p>сарын 16-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор шинээр батлагдсан БХГ-ний загварт нийцүүлэн хэлэлцээ хийх ажлыг зохион байгуулав. Эдгээр ажлын үр дүнд Эргэл XII талбайн БХГ ЗГ-ын 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан. Ийнхүү 2016 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр бүтээгдэхүүн хуваах гэрээнд гарын үсэг зурагдсан.</p> <p>- Газрын тосны хайгуулын Богд IV ба Онги V талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-нүүдийн эрх, үүргийн 78 хувийг эзэмшигч “Би Жи Монголиа Холдингс” лимитэд компани нь эдгээр БХГ-нийхээ эрх, үүргийг “Сентрал азиан петролеум корпорэйшн” лимитэд компанид <i>буцаан шилжүүлэх</i> хүсэлт гаргасныг Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)–аас судалж үзээд Газрын тосны тухай хуулийн 14.3, 14.8-д тус тус заасны дагуу дүгнэлт гарган Газрын тосны тухай хуулийн 14.4-т заасны дагуу БХГ-ний эрх, үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр УУХҮЯ-д холбогдох мэдээллийн хамт хүргүүлээд байна. Эрх үүргийг буцаан шилжүүлэхтэй холбогдуулан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн хэрэгжилтийн талаар Мэргэжлийн байгууллагын тодорхойлолтууд, БОАЖЯ-ны /2016.09.26-ны өдрийн 16/01106/ Баянхонгор аймгийн БОАЖГ-ын /2016.09.02-ны өдрийн 207/ Говь-Алтай аймгийн БОАЖГ-ын /2016.08.30-ны өдрийн 283/ тодорхойлолтуудыг гаргуулан авч холбогдох мэдээлэлд нэгтгэсэн.</p>	
<p>2.3.2. Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, санал дүгнэлт гаргах, удирдлагыг мэдээллээр хангах</p>	<p>- Хуулийн дагуу, шуурхай ажиллана - IV улирал</p>	<p>- Газрын тосны хайгуулын Сулинхээр XXIII талбайд Шунхлай энерги ХХК, Номгон IX талбайд Өмнөд Монголын газар нутгийн тос ХХК, Дарьганга XXIV талбайд Монголиа Шин И Энержи ХХК-тай тус тус шинэчлэн байгуулах ажлыг гүйцэтгэхэд хяналт тавьж ажилласан. Мөн Борзон VII талбайд Импайр Газ Монголиа ХХК, Богд IV, Онги V талбайд Капкорп монголиа ХХК, Сүхбаатар XXVII талбайд Вульф Петролеум ХХК зэрэг компаниудтай бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэн байгуулах ажлыг эхлүүлсэн.</p> <p>- Гэрээний төсөлд талбай буцаах, захиргааны зардлын хувь хэмжээ, үлдсэн хугацаанд заавал хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, удирдлагын зардлын шатлал, бүтээгдэхүүн хуваах шатлал, олборлолт нэмэгдүүлсний шатлал зэргээс өөр өөрчлөлт ороогүй бөгөөд хайгуулын үлдсэн хугацаа болон эскроу дансанд байршуулах мөнгөн хөрөнгө, тусгай зөвшөөрлийн болон гэрээнд заасан бусад төлбөрүүдийн төлөх хугацаа, засгийн газарт тавих ашигтай санал зэрэг асуудлыг тусгасан харилцан ойлголцлын</p>	

		<p>санамж бичиг байгуулан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Сулинхээр XXIII талбайд “Шунхлай энерги” ХХК, Номгон-IX талбайд “Өмнөд Монголын газар нутгийн тос” ХХК, Дарьганга XXIV талбайд “Монголиа Шин И Энержи” ХХК-тай байгуулсан гэрээнүүдийг шинэчлэн байгуулахад “Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар”-т орсон өөрчлөлтүүдийн талаарх мэдээллийг бэлтгэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Түлшний бодлогын хэлтэст хүргүүлэхээр бэлтгэж удирдлагад танилцуулсан. - АМГТГ-ын даргын 2016 оны а/20 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн ажлын хүрээнд гэрээлэгчдийн талаарх мэдээлэл нэгтгэх, Бүтээгдэхүүн хуваах загвар гэрээнд хуучин гэрээний үндсэн нөхцөлүүдийг тусгаж хэлэлцээ хийх шинэ гэрээний төслийг бэлтгэх зэрэг ажлуудыг гүйцэтгэх ажлыг удирдлагаар ханган ажилласан. - АМГТГ-ын даргын 2016 оны а/23 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн хүрээнд Тосон уул XIX, Тамсаг XXI талбайн түүхий тосны тээврийн гэрээний бодит зардлуудыг тооцох, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд МУ-ын аж ахуйн нэгжүүдийг аль болох түлхүү оролцуулах, Гэрээлэгч компани олон улсад нээлттэй тендер зарлахтай холбогдох ажлын хүрээнд Тосон уул XIX, Тамсаг XXI талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон Газрын тосны тухай хуульд Туслан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой зүйл заалтуудыг түүвэрлэн хууль эрх зүйн санал боловсруулах ажлыг зохион байгуулсан. 	
<p>2.3.3. Гэрээлэгчидтэй бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх талаар хэлэлцээ хийж, Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар”-т нийцүүлэн шинэчилэх ажлыг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Хуульд нийцүүлэн шуурхай зохион байгуулан ажиллана - IV улирал - 1 ажил үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> - АМГТГ-ын даргын 2016 оны а/20 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн ажлын хүрээнд гэрээлэгчдийн талаарх мэдээлэл нэгтгэх, Бүтээгдэхүүн хуваах загвар гэрээнд хуучин гэрээний үндсэн нөхцөлүүдийг тусгаж хэлэлцээ хийх шинэ гэрээний төслийг бэлтгэх зэрэг ажлуудыг гүйцэтгэж байна. - Борзон VII талбайд Импайр Газ Монголиа ХХК, Богд IV, Онги V талбайд Капкорп монголиа ХХК, Сүхбаатар XXVII талбайд Вульф Петролеум ХХК зэрэг компаниудтай бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэн байгуулах ажлыг эхлүүлсэн. - Сулинхээр XXIII талбайд “Шунхлай энерги” ХХК, Номгон-IX талбайд “Өмнөд Монголын газар нутгийн тос” ХХК, Дарьганга XXIV талбайд “Монголиа Шин И Энержи” ХХК-тай байгуулсан гэрээнүүдийг шинэчлэн байгуулахад “Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар”-т орсон өөрчлөлтүүдийн талаарх мэдээллийг бэлтгэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Түлшний бодлогын 	

<p>2.3.4. Бүтээгдэхүүний хангамж, техник технологийн бүтцийн нэгжүүдээс бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээ, хэлэлцээр хийхэд эрх зүйн, гэрээний төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Үндэслэлтэй санал дүгнэлт өгсөн байна - IV улирал - Гэрээний тоогоор 	<p>хэлтэст хүргүүлэхээр бэлтгэж удирдлагад танилцуулсан.</p> <p>Бүтээгдэхүүний хангамж, техник технологийн бүтцийн нэгжүүдээс бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээ, хэлэлцээр хийх, гэрээний төслийг боловсруулахад эрх зүйн, дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд CNPC харьяа China Oil компаниас газрын тосны бүтээгдэхүүн импортлох 2016 оны ээлжит хэлэлцээрийг зохион байгуулав. Уг хэлэлцээрт Петровис, Шунхлай, Магнай трейд компаниуд оролцсон болно. Уг хэлэлцээрт монгол-хятад-монгол хэлний орчуулгыг гүйцэтгэв. Үр дүнд нь 2016 онд БНХАУ-аас газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх тухай гэрээ байгуулагдсан болно.</p> <p>2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс хойших хугацаанд Хий цэнэглэх станц-агуулах, автомашин хийгээр цэнэглэх станц, шатахуун түгээх станцад гаргасан техникийн дүгнэлтийн хуудсаар шаардлага хангасан 4 шатахуун түгээх станцуудад шинээр бүртгэлийн гэрчилгээ олгох тушаалын төслийг хянасан.</p>	
<p>Гурав. “Агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг эрхлэх, салбарын статистик мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг мэдээллээр хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтын хүрээнд:</p>			
<p>3.1. Хууль тогтоомж, УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнах, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, удирдах дээд байгууллагыг мэдээллээр хангах</p>		<p>3.1.1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд, УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, яаманд хүргүүлэх</p>	
<p>3.1.1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд, УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, яаманд хүргүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан журмын дагуу - IV улирал - 1 ажил үйлчилгээ 	<p>Хэлтсүүдээс ирүүлсэн төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийн болон цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энерги, газрын тосны талаар баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ хийж үнэлсэн.</p>	
<p>3.1.2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд УУХҮ-ийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, холбогдох газруудад хүргүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан журмын дагуу - IV улирал - 1 ажил үйлчилгээ 	<p>Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Ашигт малтмалын газар /хуучин нэрээр/ болон Ашигт малтмал, газрын тосны газраас хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээнүүдийн биелэлтэд хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн УУЯ-нд /хуучнаар/ хүргүүлсэн. Бүтэн жилийн биелэлтэд үнэлгээ хийж байна.</p>	
<p>3.1.4. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Ашигт малтмал, газрын тосны газрын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, холбогдох</p>	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан журмын дагуу - IV улирал - 1 ажил үйлчилгээ 	<p>Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Ашигт малтмалын газрын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлтийн тайланг хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн УУЯ-д хүргүүлсэн.</p>	

газруудад хүргүүлэх			
3.2 Газрын нэгж, албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйлчилгээний хүртээмж, чанар, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, үйл ажиллагааны ахиц дэвшил, алдаа дутагдлыг тодорхойлон, цаашид үйл ажиллагааг сайжруулах, санал зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах			
3.2.1. Ашигт малтмал, газрын тосны газрын дарга-Төсвийн шууд захирагчийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай /УУХУ-ийн сайд/ байгуулах үр дүнгийн гэрээний төсөлд хэлтсүүдийн нийлүүлбэл зохих нийт арга хэмжээ, ажил үйлчилгээ тусгагдсан эсэх талаар хяналт тавих, Нэгжийн менежерүүд болон төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээг хянах.	<ul style="list-style-type: none"> - Газрын үйл ажиллагааг бүрэн хамарч чадсан байна - IV улирал - Шаардлагатай тоо хэмжээгээр 	Төсвийн шууд захирагчийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах үр дүнгийн гэрээний төсөл, нэгжийн менежерүүдийн үр дүнгийн гэрээний төслүүдийг хянаж боловсруулаад, ТЗУХ-т 10-р сард хүлээлгэн өгсөн.	
3.2.2. Газрын үйл ажиллагааны 2016 оны нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилт, хэлтсүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үнэлэх, нэгжийн менежерүүд болон төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ, төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийг хянах, үнэлэх	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан журмын дагуу - IV улирал - Шаардлагатай тоо хэмжээгээр 	Нийт 12 хэлтсийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг цаасаар болон файлаар авч хэлтсүүдийн 4 дүгээр улирлын үр дүнгийн гэрээ, төлөвлөгөөг ТАЗ-ийн холбогдох журмын дагуу хянаж, зохих журмын дагуу үнэлэн Төрийн захиргааны удирдлагын хэлтэст цаасаар болон файлаар хүлээлгэн өгсөн. Мөн 12 хэлтсийн нийт албан хаагчдын үр дүнгийн гэрээний илтгэх хуудас болон хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтэд үнэлгээ өгсөн.	
3.2.3. Нийт албан хаагчдын ажлын цаг ашиглалт, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, тайлагнах, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох санал боловсруулах	<ul style="list-style-type: none"> - Үндэслэл бүхий хэрэгжихүйц байна - IV улирал - 1 ажил үйлчилгээ 	Ашигт малтмал, газрын тосны газрын албан хаагчдын 2016 оны 10, 11-р сарын цагийн бүртгэл, цаг ашиглалтын байдалд хяналт шинжилгээ хийж дүгнэлт гарган хэлтсийн дарга нарт зөвлөмж хүргүүлсэн.	
3.3. Дотоод хяналт, аудитын арга хэмжээг хэрэгжүүлэх			
3.3.1 Даргын тушаал, шийдвэрүүдийн биелэлттэй холбогдсон арга хэмжээ, түүний хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг тайлагнах	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан удирдамжийн дагуу - IV улирал - 1 ажил үйлчилгээ 	АМГТГ-ын даргын 2016 оны 8 сарын 25-ны өдрөөс хойш батлагдсан тушаалуудын биелэлтэд хяналт шинжилгээ хийж, дүнг гарган хэрэгжилт хангалтгүй байгаа 2 тушаалыг хэрэгжүүлэх талаар албан даалгавар гарган холбогдох хэлтэст хүргүүлсэн.	
3.3.2 Гадаад, дотоод томилолтын илтгэх хуудсуудтай танилцаж, хянах, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу томилолтоор ажиллаж, санал дүгнэлт боловсруулан удирдлагад танилцуулах	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан удирдамжийн дагуу - IV улирал - 1 ажил үйлчилгээ 	Хөдөө орон нутгийн болон гадаад томилолтуудаар хийж гүйцэтгэсэн ажил болон илтгэх хуудастай танилцан хяналт шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргасан. Уг дүгнэлт, зөвлөмжийг газрын дарга болон удирдлагын шуурхай хуралдаанд танилцуулсан.	
3.3.3 Төсвийн шууд захирагчийн багцын	- Батлагдсан журам,	ГТГ-ын /хуучин нэрээр/ 2016 оны 1-7 сар, 2 агентлаг нэгдсэнээс	

<p>4.22.2. Мэдээллийн сангийн тайлан материалыг сэргээн засварлаж, цахим хэлбэрт оруулах, программ хангамжийг сайжруулах, мэдээллийг цахимжуулах ажлыг үргэлжлүүлэх, тайлан материалаар үйлчилж, мэдээллээр хангана.</p>	<p>Тоо хэмжээ: шаардлагатай тоо хэмжээгээр Хугацаа: Тогтмол Чанар: мэдээлэл цахим хэлбэрт орсон, мэдээллээр хангасан байна.</p>	<ul style="list-style-type: none"> Анхдагчийн 120 бүртгэлийг гараар хөтөлж, шинэчлэх ажил хийгдлээ. - Архивын нөөц, ашиглалтын, нууцын, хувийн хөрөнгө, ТЭЗҮ-ийн нийт 500 ш шүүгээнд 2400 тавиурын заагч шинээр хийлээ. - Архивд хадгалагдаж байгаа хувь хүмүүсийн 325 ширхэг бүтээлийн жагсаалтаар ном гаргаж, нэр товъёог хийлээ. - Хувийн хөмрөгт хяналтын тооллого хийсэн - 2015 оны тооллогын мөрөөр авах арга хэмжээний дагуу сэргээн засаж шинэчлэх 20 зураг 20 номыг засварлав. - Төрийн архивын зааврын дагуу геологийн мэдээллийн төв архивын үйлчилгээний 12 ш дэвтрүүдийг шинэчилсэн. - Төрийн архивын зааврын 32, 33 дугаар хавсралтын дагуу хөмрөгийн тавиуруудын байрлалын заагч, заагуурыг боловсруулж гаргасан. -Цахимаар олгосон баримтын бүртгэлийн жагсаалтыг гаргаж, 2011-2015 оны өөрчлөлт хөдөлгөөний мэдээ гаргасан. - Хайгуулын төлөвлөгөө, тайлан болон уулын ажлын төлөвлөгөө, тайлангийн бүртгэлийг ном болгон хэвлэсэн. - Архивын үйлчилгээний програмыг ашиглаж эхэлсэн. Бүртгэлийн хэсэгт нэмэлт хийж байна. - Төрийн архивын зааврын 44-р хавсралтын дагуу 2013-2016 оны хооронд гаргасан 276 хүний бүтээлийн жагсаалтыг цэгцэлж хэвлэн ном болгосон. - 1:1 000 000-16 лист, 1:500 000-48 лист, 1:200 000-312 лист, 1:100000-ны масштабын 543 листийн топо зургийн бүртгэлийг цэгцлэн заагуур хийсэн. - Геологи хайгуул-2016 чуулга уулзалтад хэрэглэгдэх 1100*610 хэмжээтэй 4ш зургийг хэвлэж өгсөн. Үүнд: 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын судалгааны зураг (картограмм)-1ш, 1:200000-ны масштабтай геологийн зураглалын ажил хийгдсэн талбайн байршлын зураг (картограмм)-1ш, Монгол улсын 1:200000-ны масштабтай 	

		<p>геологийн зургийн картограмм (Улсын геологийн зураг-200)-1ш, УГЗ-200-д зориулан серийн легендэд хуваасан зураг-1ш зураг хэвлэж өгсөн</p> <p>-БОНХАЖЯ-ны Газар зохион байгуулалт болон усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын албан бичгийн хариунд шаардлагатай нийт 63 аж ахуйн нэгжийн мэдээлэл бэлтгэх ажлын хүрээнд 44 ш зураг сканердаж өгсөн.</p>	
<p>Тав. “Газрын тосны ордуудыг ашиглалтад шилжүүлэх, олборлолтыг нэмэгдүүлэх бодлогын удирдамж, гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:</p>			
5.1. Тосон-Уул XIX талбайгаас Баянхошууны хилийн боомт хүртэлх 210,7 км хатуу хучилттай авто замын 3, 4 дүгээр хэсгийг барих ажлыг зохион байгуулах			
5.1.1. Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авах ажилд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх	<p>Тоо хэмжээ: 1 ажил</p> <p>Хугацаа: Жилдээ 210,7 км хатуу хучилттай авто замын 4 дүгээр хэсэг баригдаж эхэлсэн байна.</p>	<p>- Газрын тосны газар болон Петрочайна Дачин Тамсаг ХХК хооронд зохион байгуулсан 2016 оны жилийн ажлын уулзалтаар талууд Тамсаг ХХИ талбайд ажилчдын ажиллах оффис, амьдрах орон сууц барих ажлын талаар санал солилцсон ба тухайн үед барилгын ажлын төсөв гараагүй байсан тул төсвийг урьдчилсан байдлаар 24,2 сая ам.доллараар 2016 оны ажлын төлөвлөгөөнд тусгаж, зураг төсөл бүрэн хийгдэж дууссаны дараа төсөвт өөрчлөлт оруулах талаар 2016.03.30-ны өдөр байгуулсан протоколд тусгасан.</p> <p>Петрочайна Дачин Тамсаг ХХК-иас 2016.08.17-ны өдрийн 16/1-1039 тоот албан бичгээр барилгын ажлын нийт төсвийг 20,34 сая ам.доллар болгон өөрчлөх, уг ажлыг эхлүүлэх үүднээс гэрээ байгуулах хэлэлцээрт АМГТГ төлөөллөө оролцуулах хүсэлтийг ирүүлсэн. Тус албан бичгийн хариуд АМГТГ-аас 2016.08.19-ний өдрийн 1/13 тоот албан бичгээр шинээр төсөвлөсөн 20,34 сая ам.долларын төсвийг дахин нягтлах шаардлагатай тул төсвийн нарийвчилсан задаргааг ирүүлэхийг мэдэгдсэн.</p> <p>- Петрочайна Дачин Тамсаг ХХК-иас 2016.09.01-ний өдрийн 16/1-1130 тоот албан бичгээр 20,34 сая ам.долларын төсвийн нарийвчилсан задаргаа, ажлын мэдээллийг АМГТГ-ын холбогдох мэргэжилтэнд хүргүүлж, тайлбар хийсэн бөгөөд ажиллах хүчний зөвшөөрөл оройтож гарсан, барилгын ажил явуулах хугацаа бага байгааг харгалзан гэрээ байгуулах хэлэлцээрийг яаралтай эхлүүлэх хүсэлтийг дахин тавьсан. Үүний хариуд АМГТГ-аас 2016.09.08-ны өдрийн 1/236 тоот албан бичгээр дараах шаардлагуудыг хүргүүлсэн ба гэрээлэгчээс өнөөг хүртэл хариу</p>	

		<p>ирүүлээгүй байна. Шаардлагууд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тус барилгын зураг төслийг яаралтай Монгол хэл дээр хөрвүүлж, “Барилгын тухай хууль”-ийн 23.5-д заасны дагуу МУ-ын эрх бүхий хуулийн этгээдтэй хамтран баталгаажуулах, магадлал хийлгүүлэх, 2. “Барилгын тухай хууль”-ийн 24.2-т заасны дагуу барилга байгууламжийн төсвийн тооцоог мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийлгэх, 3. Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг “Барилгын тухай хууль”-ийн 35.1.6-д заасны дагуу аймаг, нийслэлийн засаг даргаас цаг тухайд нь авах, <p>Барилгын ажил гүйцэтгэх туслан гүйцэтгэгч сонгохдоо “Газрын тосны тухай хууль”-ийн 11.2.5-д заасны дагуу Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийг оролцуулан нээлттэй сонгон шалгаруулалт явуулах.</p>	
<p>5.2. Гэрээлэгчидтэй хийх 2017 оны жилийн ажлын уулзалтыг зохион байгуулах, гэрээлэгчдийн 2016 оны газрын тостой холбогдсон үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлийг хэлэлцэн дүгнэх, мөн 2017 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг судалж, санал дүгнэлт гаргах, батлуулах</p>			
<p>5.2.1. 2017 оны жилийн төлөвлөгөө батлаж, ажлын уулзалтыг зохион байгуулах Гэрээлэгчдийн 2016 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлийг гаргах Гэрээлэгчдийн 2017 оны ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг ажлын төрөл тус бүрээр нь судалж, санал дүгнэлт гаргах 2016 оны ажлын гүйцэтгэлийг гаргаж, хэрэгжилтийг дүгнэх</p>	<p>Тоо: 2 ажил үйлчилгээ Хугацаа: IV улиралд 2016 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын гүйцэтгэл дүгнэгдэж, 2017 оны ажлын төлөвлөгөө, төсөв батлагдсан байна.</p>	<p>Газрын тосны газар /хуучин нэрээр/-ын даргын 2015 оны 165 дүгээр тушаалаар Монгол Улсын Засгийн газрын баталсан БХГ-ний дагуу Дорноговь аймгийн нутагт орших 1997 оны БХГ-т талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй Доншен газрын тос (Монгол) ХХК-тай, 2016 оны 35 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газрын баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-ний дагуу Дорнод аймгийн Тамсагийн сав газарт орших Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-тай жилийн ажлын уулзалт хийх ажлын хэсгийг тус тус байгуулж, уулзалтыг 2015 оны 12 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд, 2016 оны 3 дугаар сарын 7-30-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан.</p> <p>Жилийн ажлын уулзалтаар дээрх компаниудын 2015 оны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа, цооногийн перфораци, туршилт, үйлчилгээ, шингэн хагалбар, олборлолтын гадаргуун тоног төхөөрөмжийн угсралтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг хэлэлцэж, ажлын гүйцэтгэл гаргаж, баталгаажуулсан.</p> <p>- Петрочайна Дачин Тамсаг ХХК нь 2015 онд БХГ-т Тосон-Уул</p>	

		<p>XIX, Тамсаг XXI талбайд нийт 140 цооног өрөмдөж, 234 удаагийн 8268,1 метрт перфораци, 259 үед шингэн хагалбар, 2 цооногт температурын хэмжилт, 156 цооногт олборлолтын шахуурга суурилуулах, ус шахалтын 66 цооногт шахуурга суурилуулах, 50 цооногт гүний тоноглолыг солих, 197 цооногт шахуурга солих, шалгах, 9 цооногт их засвар, 146 цооногт бусад үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>- Доншен газрын тос (Монгол) ХХК нь 2015 онд 16 цооногийн 230,8 метрт перфораци, 16 цооногт каротаж, 9 цооног ус шахалтад шилжүүлж, хуучин 9 цооног нөхөн сэргээн олборлолтод шилжүүлж, 57 цооногт засвар үйлчилгээ зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Гэрээлэгчдийн 2016 оны ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг ажлын төрөл тус бүрээр нь хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд судлан хэлэлцэж, төлөвлөгөө, төсвийн талаар санал дүгнэлт гаргаж танилцуулсны дагуу “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 2016 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдөр, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2016 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2016 оны 3 дугаар сарын 30-ны өдөр тус тус батлуулсан. Уг ажлын хүрээнд дараах материалуудыг боловсруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тосон-Уул XIX, Тамсаг XXI болон БХГ-97 талбайн 2016 оны ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг монгол, англи хэл дээр тус бүр 2 хувь, нийт 4 хувь, - 2016 оны жилийн ажлын уулзалтын протокол, монгол англи хэл дээр (2016.03.30 болон 2015.12.16-ны өдөр тус тус байгуулсан), - Тосон-Уул XIX болон Тамсаг XXI талбайн 2016 оны нэмэлт ажлын төлөвлөгөө, төсөвт өгөх нэгтгэсэн санал, дүгнэлт <p>Мөн Петрочайна Дачин Тамсаг ХХК нь 2016.11.01-ний өдрийн 16/1-1432 тоот албан бичгээр дээрх 2 талбайн 2016 оны нэмэлт ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг АМГТГ-т ирүүлсэн ба уг төлөвлөгөө, төсвийн төслийг холбогдох мэргэжилтнүүд хариуцсан чиглэлийн хүрээнд ажлын төрөл тус бүрээр нь тухайн ажлыг гүйцэтгэсэн өмнөх жилийн гэрээ, нэгж үнэ, ажлын бодит гүйцэтгэл, үлдэж буй хугацаанд хийж гүйцэтгэх боломж, шаардлагыг нарийвчлан судалж, санал дүгнэлт гаргасан. Уг ажлын хүрээнд нийт 212 хуудас материал боловсруулсан. Үүнд:</p>
--	--	--

		<ul style="list-style-type: none"> - Тосон-Уул XIX болон Тамсаг XXI талбайн 2016 оны нэмэлт ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг монгол, англи хэл дээр тус бүр 2 хувь, нийт 4 хувь, - Тосон-Уул XIX болон Тамсаг XXI талбайн ажлын төлөвлөгөө, төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан протокол монгол, англи хэл дээр тус бүр 2 хувь, нийт 4 хувь, - Тосон-Уул XIX болон Тамсаг XXI талбайн 2016 оны нэмэлт ажлын төлөвлөгөө, төсөвт өгөх нэгтгэсэн санал, дүгнэлт <p>Тосон-Уул XIX, Тамсаг XXI болон БХГ-97 талбайн 2016 оны ажлын төлөвлөгөө, төсвийг АМГТГ-ын даргаар батлуулсан. Батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу Тосон-Уул XIX талбайд 146.3 сая, Тамсаг XXI талбайд 157.6 сая, БХГ-97 талбайд 17.1 сая ам.доллар, 3 талбайн хэмжээнд нийт 321 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөсөн.</p>	
<p>5.3. Гэрээлэгчдийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ”, “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө”, “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”-үүдийн хэрэгжилтийг хангуулах</p>			
<p>5.3.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж, гэрээлэгчдэд дэмжлэг үзүүлж, газар дээр нь хяналт тавьж ажиллах</p> <p>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайланг гаргуулж, судлан, БОАЖЯ-нд хүргүүлэх</p> <p>Ажлын гүйцэтгэлийн гаргаж, хэрэгжилтийг дүгнэх</p>	<p>Тоо: 3 талбай</p> <p>Хугацаа: IV улиралд</p> <p>Хөтөлбөрийг хэрэгжүүлж, тайланг БОАЖЯ-д хүргүүлсэн байна.</p>	<ul style="list-style-type: none"> - Петрочайна Дачин Тамсаг болон Доншен газрын тос (Монгол) ХХК-иас ирүүлсэн 2016 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийг судалж, санал дүгнэлт гарган, БОНХАЖЯ-нд хүргүүлсэн. 1997 оны БХГ-т талбайн 2016 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийг 2016 оны 2 дугаар сарын 22-ны өдөр, Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн 2016 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийг 2016 оны 7 дугаар сарын 31-ний өдөр тус тус БОНХАЖЯ-аар батлуулсан. - Байгаль орчны мониторингийн судалгааг “Бодлын нууц” ХХК 2016 оны 7 дугаар сарын 6-7 болон 9 дүгээр сарын 2-3-ны өдрүүдэд Тосон-Уул XIX талбайд хийсэн ба хээрийн судалгааны тайланг хүлээн авч, судалж байна. - Олборлолт нэмэгдүүлэх байгууламж барих, Баянхошуу, Бичигт чиглэлийн замын үнэлгээний ажлыг “ЕАСС” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд хээрийн судалгааны ажлыг 2016 оны 7 дугаар сард хийсэн боловч уг 2 үнэлгээний ажил ТЭЗҮ байхгүй шалтгааны улмаас БОАЖЯ-наас ерөнхий үнэлгээний дүгнэлт гарахгүй хүлээгдэж байна. - Газрын төлөв байдал чанарын хянан магадалгааг “Би Эс энд Би” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2016 оны 7 дугаар сард хээрийн судалгааны ажлыг хийж, тайлангаа ирүүлсэн ба уг тайланг 	

		<p>судалж байна.</p> <p>- Дүйцүүлэн хамгаалах суурь судалгааны ажлыг “Лэндс” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2016.08.07, 2016.10.03-нд тус тус хээрийн судалгааны ажлыг хийсэн. Тус компаниас 2016.11.04-ний өдрийн 11/05 тоот албан бичгээр дүйцүүлэн хамгаалалт хийх талбайг сонгоход санал өгөх хүсэлтийг ирүүлсэн. Уг албан бичгээр ирүүлсэн дүйцүүлэн хамгаалалт хийхээр төлөвлөж буй 7 талбайг бусад БХГ-т болон эрлийн гэрээт талбайтай давхцаж буйг судалсны үндсэн дээр 265078 га талбай бүхий Дорнод Монгол Улсын Тусгай хамгаалалттай газарт дүйцүүлэн хамгаалалт хийх саналыг 2016.11.21-ний өдрийн 1/1977 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Бичигт, Тосон-Уул чиглэлийн 100 км салаа замын биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг “Дорнод Дээж” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2016.07.11-2016.08.11 хүртэлх хугацаанд талбайд ажиллаж, Бичигт –Тосон-Уул чиглэлийн 20 км эвдэрсэн замыг сийрүүлж хагалсан. Тариалалт хийх үр нь өвөлжих чийг авах хүртлээ хангалттай ургах хугацаа бага байгаагаас шалтгаалан үлдсэн 80 км замыг хагалах болон үрсэлгээ хийх ажлыг 2017 оны хавар хийж гүйцэтгэхээр шийдвэрлэсэн.</p> <p>- Байгаль орчны мониторингийн судалгаа, Газрын төлөв байдал чанарын хянан магадалгааны тайланг судалж байна. Петрочайна Дачин Тамсаг ХХК нь 2016 оны байгаль орчныг хамгаалах ажлын тайлангаа орон нутгийн Байгаль орчны газарт хүргүүлсэн бөгөөд уг тайлан хянагдсаны дараа БОАЖЯ-нд хүргүүлэхээр төлөвлөж байна.</p>	
5.5. Гэрээлэгчдийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааны хөрөнгө оруулалт, зардлыг хянаж баталгаажуулахад мэргэжлийн санал, дүгнэлт гаргах			
5.5.1. Ажлын төрөл тус бүрээр гүйцэтгэл гаргах Мэргэжлийн санал дүгнэлт гаргах	Тоо: 3 талбай Хугацаа: IV улиралд Мэргэжлийн санал, дүгнэлт гаргаж холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн байна.	<p>- Гэрээлэгчдийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт, зардлыг хянаж баталгаажуулах ажлын хүрээнд 2015 онд Тосон-Уул ХИХ, Тамсаг ХХИ болон БХГ-97 талбайд хийгдсэн ажлуудын гүйцэтгэлийг ажлын төрөл тус бүрээр гаргаж, гэрээлэгчидтэй тулган баталгаажуулсан ба энэ нь аудит хийх анхдагч материал болно.</p> <p>БХГ-97 талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд оруулсан 2014 оны хөрөнгө оруулалтад санхүүгийн шалгалт хийх ажлын хэсгийн</p>	

		<p>бүрэлдэхүүнд ахлах мэргэжилтэн М.Айдын, мэргэжилтэн Б.Бас-Оргил нар орж, ажилласан.</p> <p>- 2014 онд БХГ-97 талбайд хийгдсэн газрын тосны орд ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой 23 цооногийн перфорацийн ажил, 18 хуучин цооногийн каротажийн ажил, 18 цооногийн шингэн хагалбарын ажил, 18 цооногийг олборлолтод шилжүүлэх, 10 хуучин цооногийг сэргээх, 3 цооногийн олборлолтын туршилт, 11 цооногийг ус шахалтад шилжүүлэх, 53 цооногийн засвар, үйлчилгээ, 2 хуучин цооногийн тоноглолын ажил, 9 цооногийн гадаргуун тоног төхөөрөмжийн угсралт зэрэг ажлуудын гүйцэтгэлийг ажлын төрөл тус бүрээр нь гаргаж, холбогдох төлбөрийн баримт, гэрээний хуулбар, санхүүгийн материалыг шүүн шалгаж, мэргэжлийн санал дүгнэлт гаргасан. Мөн тус талбайд 2014 онд хийгдсэн судалгааны ажлуудыг манай мэдээллийн санд ирүүлсэн эсэхийг шалгаж, ажлуудын үр дүнгийн тайлан тухайн ажлын өдөр тутмын мэдээтэй нийцэж буй эсэхийг судалсан.</p> <p>- Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн 2011, 2012, 2013 оны, БХГ-97 талбайн 2012, 2013 оны хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардалд санхүүгийн шалгалт хийх ажлын хэсгийг АМГТГ-ын даргын 2016.11.18-ны өдрийн а/36 тоот тушаалаар байгуулсан ба ажлын хэсэг ажиллаж байна.</p>	
<p>5.6. Тосон-Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайд байгуулсан гэрээний 2015 оны хэрэгжилтийг хэлэлцэн дүгнэх</p>			
<p>5.6.1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг гэрээлэгч компаниудтай хэлэлцэх Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт хангалтгүй заалтуудыг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах</p>	<p>Тоо: 3 талбай Хугацаа: IV улиралд БХГ-ний хэрэгжилтийг гаргаж, дүгнэсэн байна.</p>	<p>- Тосон-Уул XIX, Тамсаг XXI болон БХГ-97 талбайн БХГ-ний 2015 оны хэрэгжилтийн тайланг боловсруулж, төслийг файл хэлбэрээр 2016 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гэрээлэгч компаниудад хүргүүлсэн.</p> <p>- “Доншен газрын тос (Монгол)” ХХК БХГ-97 талбайн БХГ-ний 2015 оны хэрэгжилтийн тайлангийн төсөлтэй танилцаж, хариу ирүүлсэн. Тус компаниас ирүүлсэн саналд тусгагдсан санхүүгийн холбогдолтой мэдээллүүдийг хянуулахаар ТЗУХ-т 2016.11.30-ны өдөр хүргүүлсэн. Санхүүгийн мэдээллүүдийг хянаж, нягталсны дараа БХГ-ний хэрэгжилтийг 2 тал хэлэлцэж баталгаажуулна.</p> <p>- Петрочайна Дачин Тамсаг ХХК-иас хариу ирүүлээгүй байгаа ба тус компанийн удирдлагуудтай 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдөр буюу 2017 оны жилийн ажлын уулзалтын үеэр уг асуудлаар уулзаж, Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн БХГ-ний 2015 оны хэрэгжилтийг хэлэлцэж, баталгаажуулахаар тохиролцоод байна.</p>	

5.7. Гэрээлэгчийн туслан гүйцэтгэгч компаниудтай 2016 онд байгуулах газрын тостой холбогдсон үйл ажиллагааны гэрээ, хэлэлцээрт оролцох, санал дүгнэлт гаргах		
5.7.1. Гэрээ, хэлэлцээрт оролцох Гэрээлэгчийн туслан гүйцэтгэгч компанийн үйл ажиллагаанд Газрын тосны тухай хуулийн хүрээнд дэмжлэг үзүүлэх	Тоо: Шаардлагатай тоо хэмжээгээр Хугацаа: IV улиралд Ажил гүйцэтгэх гэрээнүүд байгуулагдсан байна.	<ul style="list-style-type: none"> - Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн 2016 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэх туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ахлах мэргэжилтэн Ч.Чулуунбат, мэргэжилтэн Х.Анхбаатар нар 2016.04.09-10-ны өдрүүдэд оролцсон. Сонгон шалгаруулах үйл ажиллагаанд 25 компани оролцож, нийт 61 гэрээ байгуулагдсан. Мөн Тамсаг XXI талбайн газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд ашиглах зорилгоор худалдан авах тосны цооногийн тестер, шахуурга, лабораторийн тоног төхөөрөмж, шингэний төвшин хэмжигч индикатор зэрэг төхөөрөмжүүдийг худалдан авах гэрээний төслийг судалж, санал дүгнэлт гаргаж, удирдлагад танилцуулсны үндсэн дээр худалдан авалтын 7 гэрээ байгуулагдсан. - БХГ-97 талбайн 2016 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэх туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ахлах мэргэжилтэн Ч.Чулуунбат оролцсон. - Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн үйл ажиллагаанд шаардлагатай байгаа бараа материал, тоног төхөөрөмж худалдан авах үйл ажиллагаанд 2016.09.26-29-ний өдрүүдэд ГТАХ-ийн дарга О. Энхбаяр, ахлах мэргэжилтэн М.Айдын, ТЗУХ-ийн дарга Б.Дашпүрэв, ахлах мэргэжилтэн Ш.Маргад нар оролцсон ба худалдан авах үйл ажиллагааны үр дүнд 38 гэрээ байгуулагдсан. - 2016.09.16-ны өдөр Петрочайна Дачин Тамсаг ХХК, Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайгаас Бичиг, Баянхошууны хилийн боомт чиглэлд газрын тосны экспортын тээвэр гүйцэтгэж буй CNPC, Jilin huanyang, Jingtian, Bohai, Great wall, New istan компаниудын төлөөлөлтэй хэлэлцээр хийж, 2016 оны тээврийн үнийг хэлэлцсэн. Хэлэлцээрийн үр дүнд 2015 онд мөрдөж байсан тээврийн үнийг 6 хувиар бууруулж, нэг баррель тосыг зүүн чиглэлд км тутамд 0,0197, урд чиглэлд 0,0195 ам.доллар байхаар шийдвэрлэж, уг үнийг 2016.01.01-нээс эхлэн мөрдөхөөр тохиролцсон. - Сонгон шалгаруулах үйл ажиллагааны явцад туслан гүйцэтгэгч компаниудын зүгээс зах зээл дээрх ажлын хөлс, материалын үнэ өссөнтэй холбоотойгоор ажлын зардлыг өсгөх саналыг удаа дараа гаргаж байсан. Газрын тосны газрын зүгээс тухайн ажлын нэгж үнийг батлагдсан жишиг үнэ болон 2016 оны ажлын

		төлөвлөгөө, төсөвт тусгасан үнэд нийцүүлэн гэрээ байгуулах талаар чиглэл баримтлан ажилласны үр дүнд ажлын нэгж үнийг төсвийн үнэд багтаан гэрээнүүдийг байгуулсан.	
Зургаа. “Газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг тогтвортой, олон эх үүсвэрээс хангах чиглэл баримтлах, санал боловсруулах, байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, аюулгүй, стандартын шаардлага хангасан газрын тос бүтээгдэхүүний барилга байгууламж, техник технологи, тоног төхөөрөмжөөр үйл ажиллагаа явуулах бодлогыг хэрэгжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:			
6.2. Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох үйл ажиллагаанд тээвэрлэлтийн аливаа саатал гарсан тохиолдолд холбогдох байгууллагуудад хандах, тээвэрлэлтийг саадгүй явуулах талаар арга хэмжээг тухай бүр авах			
6.2.1. Гашуун сухайт хилийн боомтоор БНХАУ-ын Хөх хотын боловсруулах үйлдвэрээс газрын тосны бүтээгдэхүүнийг авто машинаар тээвэрлэх туршилтын ажлыг эхлүүлнэ.	Тоо хэмжээ: 1 удаа Хугацаа: III-IV улирал Туршилтын тээвэрлэлтийг холбогдох газруудтай хамтран эхлүүлсэн байна	Монгол, Хятадын зам тээврийн байгууллагууд 2015 онд автоцистернээр шатахуун тээвэрлэх замын маршрутыг судалж, Хөх хотын боловсруулах үйлдвэрээс Ганц мод-Гашуун сухайтын боомтоор Цогтцэций, Ханбогд хүртэл шатахуун тээвэрлэх замын маршрутыг боломжтой гэсэн дүгнэлтийг гаргасан. Гашуун сухайт хилийн боомтоор БНХАУ-ын Хөх хотын боловсруулах үйлдвэрээс газрын тосны бүтээгдэхүүнийг авто машинаар тээвэрлэх туршилтын ажлыг Шунхлай компани 2016 онд хийж хилийн боомт хүртэл тээвэрлэсэн боловч боомтоор нэвтрүүлж чадаагүй.	
6.4. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, нөөцийн бүтээгдэхүүнийг хадгалах гэрээг холбогдох байгууллагуудтай хийх, нөөцийн хадгалалтанд хяналт тавих, сэлгэх, нөхөн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах			
6.4.1. МУ-ын Засгийн газрын 2014 оны 303, 2014 оны 329 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. Улсын нөөцийн шатахууныг сэлгэх тухай Засгийн газрын шийдвэр гаргуулна, Улсын нөөцийн шатахууныг сэлгэх гэрээг компаниудтай байгуулна. Улсын нөөцийн шатахууныг нэмэгдүүлэх хөрөнгийн эх үүсвэрийн талаар холбогдох хүсэлтийг УУХҮЯ, СЯ-нд хүргүүлэх, ЗГ-аар шийдвэр гаргуулна. Хөрөнгийн эх үүсвэр шийдэгдсэн тохиолдолд улсын нөөцийн шатахууныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. Улсын нөөцийн шатахууны хадгалалтанд хяналт тавьж ажиллана	Тоо хэмжээ: 6 удаа Хугацаа: I-IV улирал Улсын нөөцийн бүрдүүлэлттэй холбогдсон тооцоо судалгаа гарсан байна. Газрын тосны бүтээгдэхүүний Улсын нөөцийг бүрдүүлсэн байна.	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу улсын нөөцийн шатахууныг хадгалах гүйцэтгэгчийг, компаниудын дунд тендер зарлан сонгон шалгаруулж, хадгалуулдаг. Гэвч Уул уурхайн сайдын /хуучин нэрээр/ 2016 оны батлагдсан төсөвт Улсын нөөцийн шатахууны хадгалалтын зардал тусгагдаагүйн улмаас улсын нөөцийн шатахууныг хадгалах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдах боломжгүй болсон. Иймд улсын нөөцийн шатахууны хадгалалтын зардалд шаардагдах хөрөнгийг 2016 оны төсвийн тодотголд суулгуулах, “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн шатахууныг сэлгэх гэрээ”-ний хугацааг сунгуулах талаар танилцуулга, тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар оруулж шийдвэрлүүлэх чиглэл хүсч, 2016 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн.2/196 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүний үр дүнд: - Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн шатахууны тухай асуудлыг хэлэлцээд “Газрын тосны	

		<p>бүтээгдэхүүний улсын нөөцийн шатахууныг сэлгэх гэрээ"-ний хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тул "Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн шатахууныг сэлгэх гэрээ"-нд нэмэлт өөрчлөлт оруулан, нөхөн бүрдүүлэх хугацааг 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгаад байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 412 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын нөөцийн шатахууныг 84720 тн буюу 30 хоногийн нөөц бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх талаар тооцоо судалгааг гарган, танилцуулгын хамт холбогдох хүсэлтийг СЯ, ЭЗХЯ, УУЯ-нд хүргүүлсэн./2016-01-26-ны 1/127 тоот/</p>	
6.5. Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг бүс нутгаар болон эдийн засгийн голлох салбаруудаар гаргаж, удирдлагыг мэдээллээр хангах			
6.5.1. Газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг бүс нутгаар, эдийн засгийн голлох салбаруудаар гаргаж, өнөөгийн болон хэтийн төлвийн талаар харьцуулсан дүгнэлт гаргах, мэдээллийн санг шинэчлэнэ. Шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн шатахууны жижиглэн болон бөөний борлуулалтын мэдээ, судалгааг авч нэгтгэх	Тоо хэмжээ: 4 удаа Хугацаа: Улирал бүр Монгол Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээний дэлгэрэнгүй судалгааг гаргасан байна.	- Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг бүс нутаг, эдийн засгийн голлох салбаруудаар, өнөөгийн болон хэтийн байдлын талаар судалгааг гарган удирдлагыг мэдээллээр хангаж байна. Баруун аймгуудад газрын тосны бүтээгдэхүүний үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын хэрэглээг гаргав. Мөн газрын тосны бүтээгдэхүүн импортлогч компаниудаас сар болгоны 10-нд борлуулалтын тайланг нэгтгэн боловсруулж удирдлагад танилцуулж байна. Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй томоохон уул уурхайн компаниудын шатахууны хэрэглээний судалгааг гаргав. 2003-2020 он хүртэлх шатахууны хэтийн төлөвийн судалгааг гаргаж удирдлагад танилцуулж мэдээллийн санг баяжуулсан.	
6.5.2. Шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн шатахууны жижиглэн болон бөөний борлуулалтын мэдээ, судалгааг авч нэгтгэх	Тоо хэмжээ: 12 удаа Хугацаа: Сар бүр Мэдээллийн сан баяжигдсан байна	- Шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн жижиглэн болон бөөний борлуулалтын нарийвчилсан судалгаа хийж баяжилт хийгдсэн. Монгол Улсын шатахууны нийт хэрэглээний 58,6 хувь нь Улаанбаатар хотод, 41,4 хувь нь хөдөө орон нутагт борлуулагдаж байна. Улаанбаатар хотод нийт шатахууны хэрэглээний 5 хувийг 90-ээс доош октантай автобензин, 90-ээс дээш октантай автобензин 46 хувийг, 49 хувийг дизелийн түлш эзэлж байна.	
6.6. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулах барих ажлын талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах			
6.6.1. Улаанбаатар хотын Рашаант өртөөнд баригдаж буй улсын нөөцийн агуулахын барилга угсралтын ажил концессын гэрээгээр үргэлжилсэн тохиолдолд барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт	Тоо хэмжээ: 1 ажил Хугацаа: 1-4 улиралд Хяналт тавин, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан	Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн "317-р тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 321 дүгээр тогтоол, Концессын тухай хуулийн 6.1.2, 19.1-д заасныг үндэслэн "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 2015 оны 3-р сарын 30-ны өдрийн 119 дүгээр тогтоолоор Концессын "барих-өмчлөх-	

тавьж ажиллана.	байна.	<p>ашиглах” төрлөөр хэрэгжүүлэх Рашаант дахь улсын нөөцийн агуулах төслийн гэрээг “Нэйшнл Трейдинг энд Транспорт групп” ХХК-тай байгуулах эрхийг Хөрөнгө оруулалтын газар, Аж үйлдвэрийн сайдад ЗГ-аас даалгасан байдаг. Уг ажлын хүрээнд МУ-ын ЗГ болон “Нэйшнл Трейдинг энд Транспорт групп” ХХК-ны хооронд Рашаант дахь улсын нөөцийн агуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээг “барих-өмчлөх-ашиглах” хэлбэрээр 2015 оны 04 сарын 10-ны өдөр байгуулсан.</p> <p>Төслийг концессод шилжүүлэхтэй холбогдуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Уул уурхайн сайд, Сангийн сайд болон “Нэйшнл Трейдинг энд Транспорт групп” ХХК-тай “Улсын шатахууны нөөц хадгалах, хадгалуулах, түүнд хяналт тавих гэрээ”-г 2015 оны 06 дугаар сарын 19-ны өдөр байгуулсан. - Концессын гэрээний ажлын хүрээнд газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг, ажлын зураг төсөл, техникийн нөхцөлүүд, барилга угсралтын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, хийгдсэн ажлын гүйцэтгэл ба санхүүжилтийн танилцуулга, барилга угсралтын ил, далд ажлын актууд, барилга угсралтын ажилд хэрэглэсэн түүхий эд, бараа материалын талаарх хөндлөнгийн шинжилгээний лабораторийн дүгнэлтүүд зэрэг холбогдох бичиг баримтуудыг “Нэйшнл Трейдинг энд Транспорт групп” ХХК-д бүрэн гүйцэд шилжүүлэн өгсөн. - Концессын гэрээний 2.2.2-д заасны дагуу манай газар нь Захиалагчийг төлөөлөн агуулахын зураг төслийг боловсруулах ажлын зургийн даалгаврын төслийг боловсруулж, батлуулахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. <p>Хүрсэн үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> - Концессын гэрээний 1.7. дэх заалт Гэрээнд талууд гарын үсэг зурснаас хойш 8 сарын дотор концесс эзэмшигч нь дор дурдсан нөхцөлийг бүрэн хангаснаар гэрээ хүчин төгөлдөр болно, <p>Концессын гэрээний 1.7.4. дэх заалт Төслийн санхүүжилтийн эхний ээлжийн 12,000,000.00 /арван хоёр сая/ ам.долларыг</p>
-----------------	--------	--

		<p>энэхүү гэрээг байгуулсан өдрөөс хойш 6 сарын дотор Монгол улсын аль нэг арилжааны банкин дахь өөрийн дансанд байршуулж төслийн зориулалтын дагуу зарцуулах гэж заасан байдаг. Үүний дагуу “Нэйшнл Трейдинг энд Транспорт групп” ХХК нь “Рашаант дахь улсын нөөцийн агуулах төсөл”-ийн санхүүжилтийг Хөгжлийн банкаар дамжуулан татах хүсэлтээ Сангийн яам болон Хөгжлийн банкинд гаргасан. Хөгжлийн банк анхан шатны судалгааг хийж Сангийн яаманд хүргүүлсэн ба одоогоор тогтоол шийдвэр гараагүй байгаа учир Чех улсаас татах санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй байна.</p>	
<p>6.7. Шинээр ашиглалтанд орсон болон шинэчлэл хийгдсэн агуулах, шатахуун түгээх станцуудын савыг улсын бүртгэлд бүртгэх, дугаар олгох, эзэмшигчдэд хүргүүлэх, мэдээллийн санд баяжилт хийх,</p>			
<p>6.7.1. Шинээр ашиглалтанд орсон болон шинэчлэл хийгдэж буй ГТБА, ШТС-уудын савыг дугаар олгон, улсын бүртгэлд бүртгэнэ.</p>	<p>Тоо хэмжээ: 1 ажил Хугацаа: 1-4 улиралд Журмын дагуу хийсэн байна.</p>	<p>2016 онд дараах ШТС, Шингэрүүлсэн шатдаг хийн байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд ашигт малтмал, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн байгууллагын төлөөллөөр оролцож ажиллав. Үүнд: ШШХ-н байгууламж: - “Дашваанжил” ХХК-ийн УБ хот СХД 20-р хороо /хий цэнэглэх станцын өргөтгөл/ АХЦС: 1. “Дашваанжил” ХХК-ийн УБ хот ХУД 4-р хороо /АХЦС/ 2. “Дашваанжил” ХХК-ийн УБ хот БНД 2-р хороо 3. “Дашваанжил” ХХК-ийн Сэлэнгэ аймаг Сайхан 4. “Дашваанжил” ХХК-ийн Дархан-Уул аймаг Шарын гол сум 5. “Горгаз” ХХК-ийн УБ хот БЗД 25-р хороо /автомашин хийгээр цэнэглэх станц/ 6. “Горгаз” ХХК-ийн Дархан-Уул аймаг Дархан сум 7. “Горгаз” ХХК-ийн Орхон аймаг Баян-Өндөр сум 8. “Юнигаз” ХХК-ийн УБ хот ХУД 10-р хороо 9. “Юнигаз” ХХК-ийн УБ хот БГД 4-р хороо 10. “Юнигаз” ХХК-ийн Дархан-Уул аймаг Дархан сум 11. “Гурвалж газ” ХХК-ийн УБ хот ЧД 5-р хороо 12. “Нью энержи ойл” ХХК-ийн БЗД-ийн 8 хороонд байрлах АХЦ 13. “Шунхлай трейдинг” ХХК-ийн БЗД-ийн 7 хороонд байрлах АХЦС 14. “Шунхлай трейдинг” ХХК-ийн БЗД-ийн 14 хороонд байрлах АХЦС 15. “Шунхлай трейдинг” ХХК-ийн ХУД-ийн 4 хороонд байрлах</p>	

		<p>АХЦС</p> <p>16. “Шунхлай трейдинг” ХХК-ийн СХД-ийн 20 хороонд байрлах АХЦС</p> <p>ШТС:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Сангийн далай холдинг” ХХКУБ хот БНД 1-р хороо /шатахуун түгээх станц/ 2. “Магнай–Трейд” ХХК-ийн Дорноговь аймгийн Замын-Үүд сум, 3. “Магнай–Трейд” ХХК-ийн Завхан аймаг, Тосонцэнгэл сум ШТС-ын шинэчлэл, 4. “Петровис” ХХК-ийн Улаанбаатар хотын СХД-ийн 20-р хороонд байрлах ШТС-37 5. “Нью энерги ойл” ХХК-ийн БЗД-ийн 8 хороонд байрлах ШТС 6. “Шижир-Ойл” ХХК-ийн БЗД-ийн 13-р хороонд байрлах ШТС 7. “Шинэ ундарга ойл” ХХК-ийн СХД-ийн 20-р хороонд байрлах ШТС 8. “Тэс петролиум” ХХК-ийн Ховд аймгийн Булган сумын ШТС 9. “Тэс петролиум” ХХК-ийн Ховд аймгийн Дарви сумын ШТС 10. “Ник” ХХК-ийн Ховд аймгийн Дарви сумын ШТС 11. “Ник” ХХК-ийн Ховд аймгийн Манхан сумын ШТС 12. “Шунхлай” ХХК-ийн Ховд аймгийн Дарви сум ШТС 13. “СодМонгол групп” ХХК-ийн Сэлэнгэ аймаг, Мандал сум ШТС 14. “Тэспетролиум” ХХК-ийн Сэлэнгэ аймаг, Дулаанхан сум ШТС 15. “Гранд восток Монголиа” ХХК-ийн Дорнод аймаг, Хэрлэн сум ШТС <p>Улсын комисс хүлээн авсан автомашин хийгээр цэнэглэх станцыг мэдээллийн санд бүртгэн баяжилт хийсэн. /байршил, хүчин чадал, сав, түгээгүүр гэх мэт/</p>	
6.7.2. Савны паспортын мэдээллийн санд баяжилт хийнэ.	Тоо хэмжээ: 1 ажил Хугацаа: 1-4 улиралд Журмын дагуу хийсэн байна.	Тухай бүр савны паспортын мэдээллийн санд баяжилт хийгдсэн.	
6.8. Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, сунгуулахаар техникийн дүгнэлт хүсч ирүүлсэн өргөдлийн дагуу газар дээр нь үзлэг хийж, техникийн дүгнэлт гаргах			
6.8.1. Шатахуун түгээх станц, автомашин хийгээр цэнэглэх станцын техникийн дүгнэлт гаргаж	Тоо хэмжээ: 1 ажил Хугацаа: 1-4 улиралд Журмын дагуу хийсэн	2016 онд газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах техникийн дүгнэлт гаргуулахаар материалаа ирүүлсэн аж ахуй нэгжийн агуулахын техник,	

	<p>байна.</p>	<p>технологийн байдалд газар дээр нь үзлэг, шалгалтыг хийж ажилласан. Үүнд: 1. “Жаст Ойл” ХХК УБ хот, СХД 20-р хороо /7700 м3/ 2. “Шунхлай говь” ХХК Дорнод аймаг, Хэрлэн сум /2550 м3/ Дорноговь аймаг, Сайншанд сум /14400 м3/ 3. “Шунхлай трейдинг” ХХК УБ хот, СХД 20-р хороо /29000 м3/ 4. “Шунхлай петролиум” ХХК Орхон аймаг, Баян-Өндөр сум /1100 м3/ 5. “Смарт торх” ХХК УБ хот, СХД 20-р хороо /44000 м3/ 6. “Юнигаз” ХХК УБ хот, БЗД 10-р хороо /хий цэнэглэх станц 2400 м3/ 7. “Дашваанжил” ХХК УБ хот, СХД 20-р хороо /хий цэнэглэх станц 1400 м3/ 8. “Горгаз” ХХК УБ хот, СХД 20-р хороо /хий цэнэглэх станц 1250 м3/ 2016 онд 10 аж ахуй нэгж техникийн дүгнэлт хүсч материалаа ирүүлснээс шаардлага хангасан 8 аж ахуй нэгжийн 9 агуулахад техникийн дүгнэлт гаргасан байна. Хүрсэн үр дүн: 8 аж ахуй нэгжийн 9 агуулахын техник, технологийн байдалд техникийн дүгнэлт гарган эзэмшигч компаниуд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлэв.</p>	
<p>6.8.2. Шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний агуулах, хий цэнэглэх станц, шатахуун түгээх станц, автомашин хийгээр цэнэглэх станцад бүртгэлийн гэрчилгээ олгоно.</p>	<p>Тоо хэмжээ: 1 ажил Хугацаа: 1-4 улиралд Гэрчилгээ олгож УУХҮЯ, эзэмшигчид хүргүүлсэн байна.</p>	<p>Шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний агуулах, хий цэнэглэх станц болон автомашин хийгээр цэнэглэх станцад гаргасан техникийн дүгнэлтийг үндэслэн Газрын тосны газрын даргын 68, 88, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 101, 104, 108 дугаар тушаалаар дараах аж ахуй нэгжүүдэд бүртгэлийн гэрчилгээг олгоод байна. Үүнд: Газрын тосны бүтээгдэхүүний агуулах: - “Жаст Ойл” ХХК-ийн 1 - “Шунхлай говь” ХХК-ийн 2 - “Шунхлай трейдинг” ХХК-ийн 1 - “Шунхлай петролиум” ХХК-ийн 1 - “Смарт торх” ХХК-ийн 1 - “Юнигаз” ХХК-ийн 1</p>	

		<ul style="list-style-type: none"> - “Дашваанжил” ХХК-ийн 1 - “Горгаз” ХХК-ийн 1 <p>Автомашин хийгээр цэнэглэх станц:</p> <ul style="list-style-type: none"> - “Казгаз” ХХК-ийн 1 - “Горгаз” ХХК-ийн 4 - “Дэт” ХХК-ийн 1 - “Гурвалж газ” ХХК-ийн 1 - “Гэрийн илч газ” ХХК-ийн 2 - “Ойн бирж” ХХК-ийн 1 - “Ганга зайвар” ХХК-ийн 1 - “Юнигаз” ХХК-ийн 1 - “Чэс” ХХК-ийн 1 - “Дашваанжил” ХХК-ийн 2 <p>ШТС:</p> <ul style="list-style-type: none"> - 2016 оны 1 дүгээр сарын 11-ний №01 тушаал 8 ШТС-д - 2016 оны 1 дүгээр сарын 19-ний №11 тушаал 7 ШТС-д - 2016 оны 2 дугаар сарын 01-ний №20 тушаал 9 ШТС-д - 2016 оны 3 дугаар сарын 15-ны №43 тушаал 2 ШТС-д - 2016 оны 4 дүгээр сарын 07-ны №53 тушаал 4 ШТС-д - 2016 оны 5 дугаар сарын 03-ны №68 тушаал 4 ШТС-д - 2016 оны 6 дугаар сарын 08-ны №83 тушаал 3 ШТС-д - 2016 оны 6 дугаар сарын 10-ны №88 тушаал 1 ШТС-д - 2016 оны 6 дугаар сарын 27-ны №93 тушаал 7 ШТС-д - 2016 оны 7 дугаар сарын 06-ны №101 тушаал 5 ШТС-д - 2016 оны 10 дугаар сарын 13-ны №а/14 тоот тушаал 2 ШТС-д - 2016 оны 11 дүгээр сарын 13-ны №а/39 тоот тушаал 2 ШТС-д <p>Бүртгэлийн гэрчилгээг тусгай зөвшөөрлийн хавсралтад тэмдэглүүлэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Хүрсэн үр дүн: Нийт 10 ААН-ын газрын тосны бүтээгдэхүүний агуулах, 15 автомашин хийгээр цэнэглэх станц, тушаалаар 25 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 55 шатахуун түгээх станцад бүртгэлийн гэрчилгээг олгон эзэмшигч компаниуд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн</p>	
<p>Долоо. "Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уул уурхайн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг нь хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, үүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:</p>			

7.1. Экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлж, гааль, татвар, мэргэжлийн хяналт зэрэг төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр, эсхүл нэг цэгт үзүүлж, чирэгдлийг багасгана.		
7.1.1. Улсын хилээр гадаргуун болон гүний усны шинжилгээ, баяжуулалт, хагас үйлдвэрлэл, технологийн туршилт, шинжилгээний зориулалтаар ашигт малтмалын хүдэр, баяжмал, чулуулгийн дээж нэвтрүүлэх тухай тодорхойлолтыг журмын дагуу харьяа гаалийн хороо, газарт гаргаж өгөх.	Тоо - Шаардлагатай тоо хэмжээгээр Чанар - Үр дүнд суурилсан үндэслэл сайтай Хугацаа: 4-р улиралд	<ul style="list-style-type: none"> - Улсын хилээр гадаргуун болон гүний усны шинжилгээ, баяжуулалт, хагас үйлдвэрлэл, технологийн туршилтын зориулалтаар дээж нэвтрүүлэх тухай 129-н тодорхойлолтыг журмын дагуу аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, орд газрын шинжилгээ, судалгаа хийлгэх шаардлага зэргийг судлаад холбогдох харьяа гаалийн хороо, газарт хүргүүлсэн. - Ашигт Малтмал, Газрын Тосны Хэрэг Эрхлэх газрын дарга, Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын даргын хамтран баталсан 2007 оны 471/816 дугаар тушаалын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдээс ирүүлсэн 2016 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн улсын хилээр бүтээгдэхүүн экспортлох 6 аж ахуйн нэгжийн тодорхойлолтыг Гааль, татварын ерөнхий газарт хүргүүлэв.
7.2. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.		
7.2.1. Уул уурхайн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын хөрөнгө оруулалтын мэдээллийн санг хөтлөх. Гадаадын болон дотоодын хөрөнгийн зах зээлээс Монголын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт оруулж буй компаниудын хувьцааны үнэ ханшийн судалгаа хийх.	Тоо - шаардлагатай тоо хэмжээгээр, 1 санал Чанар - Үндэслэл сайтай Хугацаа: 4-р улиралд	<ul style="list-style-type: none"> - Хөрөнгө оруулалт шаардлагатай тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагуудын төслийг цуглуулан УУЯ-ны Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн н.Мэргэнд и-мэйл хаягаар хүргүүлсэн. - Хөрөнгө оруулалтыг сайжруулахад хийгдэх ажлын саналыг орлогч дарга М.Энхжаргалд хүргүүлсэн. Хэлтсүүдийн саналууд орлогч дарга дээр нэгтгэгдсэн. - Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд хийгдэх ажлын төлөвлөгөөг гаргасан. - Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд хийгдэх ажлын талаар УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд танилцуулсан. - Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүүгийн тайлан болон Уулын ажлын тайлангаас хөрөнгө оруулалтын мэдээг авч нэгтгэв. - Гадаадын болон дотоодын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй компаниудын хувьцааны үнэ ханшийн судалгаа хийн түүнийг тогтмол хөтөлж байна. - Хөрөнгө оруулалтаа шийдээгүйн улмаас үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжүүдийн судалгааг хийв.

		<ul style="list-style-type: none"> - Канадын Фрейзерийн хүрээлэнгээс гаргасан улс, орнуудын Хөрөнгө оруулалт татах чадварын индексийн судалж МУ-ын үзүүлэлт ямар байгааг удирдлагад танилцуулсан. - Орлогын ажиглагч хүрээлэнгээс гаргасан Байгалын баялгийн засаглалын индексийн судалж МУ-ын үзүүлэлт ямар байгааг удирдлагад танилцуулсан. - Гадаадын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж байгаа хувьцаануудын мэдээллийг 7 хоног бүр шинэчилж АМГ-ын холбогдох хэлтэс, ажилтнуудад тогтмол танилцуулан үнэ ханшийн судалгааг тогтмол шинэчлэн ажиллаж байна. - Хөрөнгө оруулалтаа шийдээгүйн улмаас үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжүүдийн судалгааг хийв. - Лондонгийн металлын биржийн түүхий эдийн үнийн мэдээллийг голлох ашигт малтмал тус бүрээр авч, өдөр тутмын үнийн мэдээллийн санд нэгтгэн ажиллаж байна. - 7 хоног бүр УУЯ-нд голлох ашигт малтмалын үнийг na nyamkhuu@yahoo.com хаягаар хүргүүлж байна. - Уул уурхайн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний 2015 оны 12 сараас 2016 оны 11 дугаар сарын зах зээлийн үнийн мэдээллийг нэгтгэн боловсруулж, АМГТГ-ын цахим хуудсанд сар бүр байршуулдаг “Статистик мэдээ” эмхтгэлд гаргуулахаар ХШҮСХ-т хүргүүлсэн. - www.umetal.com сайтруу Монгол улсаас БНХАУ-руу экспортолсон төмрийн хүдрийн үнэ ташаа нийтлэгдэж байгаа талаар мэйл бичиж, Монгол улсаас БНХАУ-руу экспортолсон төмрийн хүдрийн үнийн эх сурвалжийг Замын-Үүд боомтын үнээр авч мэдээллийг сайтад нийтэлдэг болох талаар санал солилцож, тохиролцоонд хүрсэн. - Уул уурхайн гаралтай экспортын жишиг үнийг тогтоох хорооны хуралд оролцож 1-12 дугаар сард баримтлах жишиг үнийг гаргахад санал өгч ажиллалаа. 	
<p>7.4. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд орон нутгийн удирдлагын хүлээх хариуцлагыг тодорхой тусгаж, хэрэгжилтэд нь тавих хяналтыг сайжруулах чиглэлээр холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулна.</p>			
<p>7.4.1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-д орон нутгийн удирдлагын хүлээх хариуцлагыг тодорхой тусгасан нэмэлт өөрчлөлтийг багтаасан шинэчилсэн төслийг боловсруулах, түүнд санал авах, Уул уурхай, хүнд үйлдвэрийн</p>	<p>Тоо- шаардлагатай тоо хэмжээгээр Чанар- хууль, журмын дагуу, хүртээмжтэй Хугацаа: 4-р улиралд</p>	<p>- “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын төсөлд санал авах тухай УУЯ-ны албан бичигт уг журмын төсөлд орон нутгийн удирдлагын хүлээх хариуцлага болон бусад асуудлыг тусгасан 14 саналыг нэгтгэн 2016.02.18-ны өдрийн 1/1182 тоот хариу албан бичгийг УУЯ-нд /хуучнаар/ хүргүүлсэн.</p>	

<p>яаманд хүргүүлэн батлуулах арга хэмжээ авах.</p>			
<p>7.4.2. Азийн сангийн “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь II” төсөлтэй хамтран “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн зааварчилгаа”-ны төслийг боловсруулах, санал авч холбогдох байгууллагад хүргүүлэн батлуулах арга хэмжээ авах.</p>	<p>Тоо- шаардлагатай тоо хэмжээгээр Чанар- хууль, журмын дагуу, хүртээмжтэй Хугацаа: 4-р улиралд</p>	<ul style="list-style-type: none"> - АНУ-ын Азийн сангийн ESEC II байгаль орчныг хамгаалах төслийн төлөвлөгөөнд санал хүргүүлж 2016 оны хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран батлав. - АНУ-ын Азийн сангийн ESEC II байгаль орчныг хамгаалах төслийн багтай хамтран Баянхонгор аймагт 5 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд ажиллаж аймгийн төвд “Нутгийн ургамал үржүүлгийн газар”төслийн хэрэгжилттэй танилцан Шинэжинст суманд сэдэвчилсэн семинар зохион байгуулан Механикжсан жижиг, дунд уул уурхай болон бичил уурхайн ТББ, бичил уурхайн нөхөн сэргээлтийн ажлын талаар уулзалт, сургалт зохион байгуулж ажиллав. - АНУ-ын Азийн сангийн ESEC II байгаль орчныг хамгаалах төслийн боловсруулсан Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын хяналтын хуудасны төсөлд санал өгч төсөлд тусгуулсан. - Бичил уурхайн нөхөн сэргээлтийн зааварчилгааны төслийг боловсруулж холбогдох төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, эрдэмтэн, мэргэжилтэн, гадаадын зөвлөх, бичил уурхайчдыг хамруулсан уулзалт, семинар дээр танилцуулсан. Гарсан саналыг авч нэгтгэв. - Бичил уурхайн нөхөн сэргээлтийн зааварчилгааны төслийг эцэслэн боловсруулж Уул уурхайн сайдын 2015.02.25-ны өдрийн дугаар 34 тоот тушаалаар Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. - АНУ-ын Азийн сангийн ESEC II байгаль орчныг хамгаалах төслийн багтай хамтран 2016 онд “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн зааварчилгаа”-г гарын авлага болгон хэвлүүлж бичил уурхай үйл ажиллагаа явуулж байгаа аймаг, сум, дүүргийн мэргэжилтнүүд болон бичил уурхай эрхлэгч иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулсан. 	
<p>7.4.3. Бичил уурхайгаар олборлосон хүдрийг баяжуулахад ашиглаж буй “Баяжуулах цехэд тавигдах техникийн нөхцөл”-ийн төслийг боловсруулах, батлуулах арга хэмжээ авах.</p>	<p>Тоо- шаардлагатай тоо хэмжээгээр Чанар- хууль, журмын дагуу, хүртээмжтэй Хугацаа: 4-р улиралд</p>	<ul style="list-style-type: none"> - УУЯ, АМГ, ШХА-ын БУТ-ийн багтай хамтран 2016 оны 02 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Мандал суманд үйл ажиллагаа явуулж буй 3 баяжуулах цехийн үйл ажиллагаатай танилцан “Баяжуулах цехэд тавигдах техникийн нөхцөл”-ийн төслийг боловсруулахад шаардлагатай холбогдох судалгааг авч 	

		<p>нэгтгэв.</p> <p>- АМГ-ын удирдлагын зүгээс “Баяжуулах цехэд тавигдах техникийн нөхцөл”-ийн төсөл боловсруулах ажилд дэмжлэг авч чадаагүй тул энэ ажил хийгдээгүй.</p>	
<p>7.6. Засгийн газраас баталсан хил хязгаарын дагуу “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллана.</p>			
6.1.1 Хилийн боомтоор орж ирж буй газрын тосны бүтээгдэхүүн, компаниудын гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллах, тухай үеийн мэдээ, мэдээллийг гаргана.	Тоо хэмжээ: 12 удаа Хугацаа: Сар бүр Импортоор оруулах газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт тогтворжсон байна.	Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч томоохон 10 компанийн гэрээний биелэлтэд хяналт тавьж, импортын мэдээгээр гүйцэтгэлийг 7 хоног бүр шалгаж байна. Газрын тосны бүтээгдэхүүний импортын мэдээг газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгж, боомт тус бүрээр нэгтгэж Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Тагнуулын Ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт мэдээ, мэдээллийг хүргүүлэн ажиллав.	
6.1.2 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний үнийн мэдээлэл гаргадаг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "Аргус" болон "Платц"-аас мэдээллийг албан ёсоор авч тооцоолол гаргана.	Тоо хэмжээ: 12 удаа Хугацаа: Сар бүр Бодит мэдээлэлд тулгуурлан гаргасан байна.	Газрын тосны үнийн мэдээллийн "Платц" сайтаас ОХУ-ын "Роснефть" болон БНХАУ-ын "Чайна Ойл" компаниудын 1-11 дүгээр саруудад нийлүүлэх хилийн үнийн тооцоолол болон гадаад хилийн үнэ, валютын ханшийн нөлөөллөөс үүсч болох дотоодын үнийн өөрчлөлтийг урьдчилан гаргаж, УУХҮЯ, байгууллагын удирдлагуудад тухай бүр шуурхай танилцуулж, холбогдох судалгаа, материалыг бэлтгэн хүргүүлэв.	
6.1.3 Хилийн гаднах үнэ, валютын ханшийн нөлөөллөөс үүсч болох дотоод үнийн өөрчлөлтийг урьдчилан тооцоолж удирдлагад танилцуулах.	Тоо хэмжээ: 6 удаа Хугацаа: Жилдээ Тухайн үеийн ханшийн нөлөөллийг урьдчилан тооцоолж гаргана.	- Монгол Улс, Оросын Холбооны Улсын Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын 20 дугаар хуралдаанд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар оруулах саналыг боловсруулж УУХҮЯ-нд хүргүүлэв. Монгол Улс, Оросын Холбооны Улсын Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын 20 дугаар хуралдаанд газрын тосны бүтээгдэхүүний чиглэлээр өмнөх 19 дүгээр хуралдаанд оруулсан санал буюу 1,0 сая тонн хүртэл шатахууныг Монгол Улсад нийлүүлэх үүргийг хүлээсэн заалтыг хэвээр хадгалах саналыг дэвшүүлсэн.	

		<p>- 2016 оны 11 дүгээр сарын сүүлээр БНХАУ-ын Бээжин хотноо “Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын хамтарсан Зөвлөл”-ийн анхдугаар хуралдаан зохион байгуулагдахтай холбогдуулан уг хуралдааны хэлэлцэх сэдэвт газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар дараах саналуудыг тусгахаар хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - БНХАУ-ын “Чайна Ойл” компанийн Хөх хотын нефть боловсруулах үйлдвэрээс Ганц Мод-Гашуун сухайт хилийн боомтоор газрын тосны бүтээгдэхүүнийг Монголын шатахуун импортлогч компаниудад автоцистернээр нийлүүлэхэд Хятадын талаас хилийн боомт, гаалийн байгууллагад хилээр нэвтрүүлэх зохих зөвшөөрөл олгох асуудлыг хөндөх, - БНХАУ-ын Газрын тосны үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг томоохон компаниудын зүгээс Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх талаар санаачилга гарган амжилттай хамтран ажиллаж буйг тэмдэглээд БНХАУ-ын “Чайна-Ойл” компани нь Монгол Улсаас экспортолж байгаа газрын тосны тодорхой хувьд нь шатахуун нийлүүлэх тохиролцоогоо үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, - Монголын баруун бүсийн газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах үүднээс Такешикен-Ярантын боомтоор шатахуун нийлүүлэхэд Хятадын талаас экспортын татварыг чөлөөлөх, хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх талаар дэмжлэг үзүүлэхийг хүсэх, <p>Хүрсэн үр дүн: 2016 оны хувьд импортоор авах газрын тосны бүтээгдэхүүн тогтворжсон бөгөөд нийлүүлэлт, үнийн доголдол гараагүй болно.</p>	
<p>6.3. Баруун, зүүн бүсийн хилийн боомтуудаар бүтээгдэхүүн импортлох нөхцлийг бүрдүүлэх</p>			
<p>6.3.1. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 247 тоот тогтоолыг хэрэгжүүлэх, холбогдох байгуулагуудтай хамтран ажиллах, Монгол Улсад ашиглагдаж буй газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгслийн судалгаа гаргаж, баруун болон зүүн бүсээр газрын тосны бүтээгдэхүүн импортлох боломжийг судлах, дүгнэлт гаргах, Гашуун сухайт хилийн боомтоор БНХАУ-ын Хөх хотын</p>	<p>1 ажил үйлчилгээ IV улиралд Шингэрүүлсэн шатдаг хийн хангамж, хэрэглээний талаарх судалгаа баяжигдсан байна.</p>	<p>- Монгол Улсын зүүн болон баруун бүсийн хилийн боомтуудаар газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөл бүрдүүлэх үүднээс “Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 247 дугаар тогтоол батлагдан гарсан. Монгол-Өвөр Монголын зам тээврийн байгууллагуудын уулзалтанд Ганц мод-Гашуун сухайт, Сэхэ-Шивээ хүрэн боомтуудаар автоцистернээр шатахуун импортлох асуудлыг хөндөж тавьсан бөгөөд үүний дагуу Монгол, Хятадын зам тээврийн байгууллагууд 2015 онд автоцистернээр шатахуун тээвэрлэх</p>	

<p>боловсруулах үйлдвэрээс газрын тосны бүтээгдэхүүнийг авто машинаар тээвэрлэх туршилтын ажлыг эхлүүлнэ</p>		<p>замын маршрутыг судалж, Хөх хотын боловсруулах үйлдвэрээс Ганц мод-Гашуун сухайтын боомтоор Цогтцэций, Ханбогд хүртэл шатахуун тээвэрлэх замын маршрутыг боломжтой гэсэн дүгнэлтийг гаргасан.</p> <p>- БНХАУ-ын “Чайна Ойл” компани Хөх хотын нефть боловсруулах үйлдвэрээс Ганц Мод-Гашуун сухайт хилийн боомтоор газрын тосны бүтээгдэхүүнийг Монголын шатахуун импортлогч компаниудад нийлүүлэх бэлтгэл ажлыг хангуулж байгаа талаар 2016 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний уулзалтын үеэр мэдэгдсэн. Хятадын талаас Ганц модны боомт дээр аюултай бүтээгдэхүүн тээвэрлэхэд тусгай гарах терминал байгуулах шаардлагатай гэсэн шалтгаанаар түр хугацаагаар хойшлуулсан. Хятадын төрийн байгууллагаас шатахууны хил худалдааг түргэтгэж, зохих зөвшөөрөл өгсөн тохиолдолд Хятадын “Чайна Ойл” компани, манай импортлогч компаниуд Ганц Мод-Гашуун сухайт болон бусад боомтуудаар шатахууны худалдаа хийхэд бэлэн байгаа болно. Ганц мод-Гашуун Сухайтын тээврийн маршрут эхэлсэн тохиолдолд Гашуун сухайт боомтоор шатахуун импортлох боломж бүрдэж, төвөөс алслагдсан бүс нутаг бүтээгдэхүүний байнгын эх үүсвэртэй болж, тээвэрлэлтийн зардал хэмнэгдсэнээр орон нутгийн жижиглэнгийн борлуулалтын үнэ буурах, үнийн тогтвортой байдал бий болох зэрэг олон боломж, давуу талууд бүрдэх юм.</p> <p>- 2016 оны 11 дүгээр сарын сүүлээр БНХАУ-ын Бээжин хотноо “Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын хамтарсан Зөвлөл”-ийн анхдугаар хуралдаан зохион байгуулагдахтай холбогдуулан уг хуралдааны хэлэлцэх сэдэвт Ганц Мод-Гашуун сухайт хилийн боомт, Такешикен-Ярантын боомтуудаар газрын тосны бүтээгдэхүүн импортлоход холбогдох арга хэмжээ авах саналуудыг тусгахаар хүргүүлсэн.</p> <p>Хүрсэн үр дүн: Тодорхой хэмжээнд томоохон ажлуудыг зохион байгуулж хийсэн, БНХАУ-ын талаас асуудал шийдэгдвэл баруун болон зүүн бүсээр шатахуун импортлох нөхцөл бүрдсэн.</p>	
<p>Долоо. "Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уул уурхайн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг нь хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, үүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:</p>			
<p>7.3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах журмын хэрэгжилтийг хангах, дүрэм, заавар,</p>			

зааварчилгааг сурталчлах ажлыг зохион байгуулах.			
<p>7.3.1. Бичил уурхайн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтыг ил тод болгох механизмыг бүрдүүлэхэд чиглэсэн судалгааг баяжуулж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх.</p>	<p>Тоо- 2 санал, 1 судалгаа Чанар- Үнэн зөв, санал тайлбар хүргүүлнэ. Нэгдсэн сан үүссэн байна. Хугацаа: 4-р улиралд</p>	<ul style="list-style-type: none"> - Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг 9 аймгийн 9 сумдад бичил уурхайн үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн борлуулалттай холбоотой мэдээлэл ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн. - Хэнтий, Дорнод аймгийн 5 суманд албан томилолтоор ажиллаж 22 нөхөрлөлийн бичил уурхайгаас олборлосон бүтээгдэхүүн борлуулалтын мэдээг авч нэгтгэв. - ТБУТ, Бичил уурхайн олон улсын зөвлөх Пайтрик Шайнтэй хамтран 2016 оны 2 дугаар сард Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээний судалгааг хийсэн. Судалгааны үр дүнг 11 дүгээр сарын 14-17-ний өдрүүдэд зохион байгуулсан Зүүн-Өмнөд, Төв, Баруун бүсийн “Бичил уурхайг албажуулах замаар эдийн засагт оруулах хувь нэмрийг дээшлүүлэх нь” зөвлөгөө, 12 дугаар сарын 1-ний өдөр зохион байгуулсан “Бичил уурхайгаар олборлосон алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах бодлогын асуудлууд” сэдэвт семинар болон 12 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулсан Үндэсний чуулга уулзалт дээр тус тус илтгэл хэлбэрээр танилцуулав. - Бичил уурхайн бүтээгдэхүүн борлуулалтын талаар цаашид авах арга хэмжээний саналыг нэгтгэн УУХҮЯ-нд хүргүүлсэн. 	
<p>7.3.2. Хууль, журамд нийцүүлэн холбогдох хэлтсийн саналыг авч Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн дүгнэлт гаргах, талбайн мэдээллийг нэгдсэн санд бүртгэх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах.</p>		<ul style="list-style-type: none"> - АМТХ болон “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын дагуу Улаанбаатар хотын 3 дүүрэг, 12 аймгийн 17 сумын бичил уурхайн дүгнэлт гаргуулах тухай албан бичигт тойрох хуудас нээж АМГ-ын даргын 2015.9.7-ны өдрийн а-81 тоот тушаалаар бичил уурхайн талбайн дүгнэлт гаргах бичиг баримтын бүрдэл, “бичил уурхайн талбайн дүгнэлтийн тойрох хуудас”-ны дагуу холбогдох алба, хэлтсийн ажилтнууд танилцаж дүгнэлт гаргасан. - Бичил уурхайн талбайн дүгнэлтийн мэдээллийг санд нэгтгэж УУХҮЯ, ЦЕГ, МХЕГ болон бусад холбогдох байгууллагад мэдээ, тайлан ирүүлэх журам, хамтран ажиллах гэрээний дагуу цаг тухай бүр нь мэдээллээр хангаж ажилласан. - Бичил уурхайн бүсийн зөвлөгөө, Үндэсний чуулга болон бусад уулзалт, семинар дээр тавьж хэлэлцүүлсэн илтгэлд талбайн дүгнэлтийн мэдээллийг оруулсан. - Бичил уурхайн талбайн дүгнэлт гаргах ажлын хэсэг Дундговь аймгийн Хулд суманд 2016.04.14–16-ны өдрүүдэд албан томилолтоор ажиллаж дүгнэлт гаргасан. 	

		<ul style="list-style-type: none"> - Бичил уурхайн талбайн дүгнэлт гаргахтай холбоотойгоор Нийслэлийн Багахангай дүүрэгт 2016.05.11-ны өдөр АМГ-ын ажлын хэсэг албан томилолтоор ажиллан газар дээр нь биечлэн танилцсан. - Бичил уурхайтай холбоотой хууль, журмыг сурталчлах ажлаар Сэлэнгэ аймгийн Баянгол суманд 2016.05.30-ны өдөр албан томилолтоор ажиллаж, тус сумын бичил уурхай эрхлэгч иргэдтэй уулзалт зохион байгуулан “Бичил уурхайн хууль, журмын хэрэгжилт, өнөөгийн байдал” сэдвээр илтгэл тавьсан. 	
<p>7.3.3. Бичил уурхай эрхлэгчдэд бичил уурхайтай холбоотой хууль дүрэм, зааврыг сурталчлах, сургалт явуулах.</p>		<ul style="list-style-type: none"> - ШХА-ын Тогтвортой бичил уурхайн төсөлтэй 2016 онд хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулав. - Бичил уурхай болон хууль бусаар ашигт малтмал олборлож буй нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, орон нутгийн удирдалагуудтай уулзалт зохион байгуулах зорилгоор УУЯ, АМГ, ШХА-ын Тогтвортой бичил уурхайн төсөл хамтран Төв аймгийн Заамар сум, Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө, Хүдэр сумдуудад 2 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд албан томилолтоор ажиллав. - 2016 оны 03 дугаар сарын 30-ны өдөр МХЕГ, УУЯ, БОНХЯ-тай хамтарсан 21 аймаг 9 дүүргийн улсын байцаагч нар оролцсон семинарт Бичил уурхайн хууль эрхзүйн орчин болон бусад асуудлаар илтгэл тавьж оролцов. - Ховд аймгийн хэмжээнд зохион байгуулсан төрийн байгууллагуудын нэгдсэн уулзалтанд зориулан бичил уурхайн хууль эрх зүйн орчин болоод бичил уурхайн загвар нөхөн сэргээлтийн аргачлалын талаар мэдээлэл бэлтгэсэн. - ШХА-ын ТБУТ Бичил уурхайн сургалт, сурталчилгаа явуулах, томилолтоор ажиллахад шаардлагатай техник хэрэгсэл худалдан авч өгөв. - Увс аймгийн Тариалан суманд Бор хавцал, Мээрэн, Бургастай, Өмнөговь сумын орлогын голын нөхөн сэргээсэн талбай, Ховд аймгийн Мөст суманд “Нарийн давын ам”, Цэцэг сумын “Цагаан эрэг”, Үенч сумын “Цагаан чулуутын ам” Булган сумын “Цоохор нуур”, Алтай сумын “Халтар уул” нэртэй газруудад 10 хоногийн хугацаанд нийт 729 бичил уурхай эрхлэгч иргэд, сумдын төрийн албан хаагчдад болон хууль бус ашигт малтмал олборлож байгаа иргэдэд бичил уурхайн 308-р журмын хэрэгжилтийн талаар заавар, зөвлөгөө өгч томилолтоор ажиллав. 	

		<p>- Увс аймгийн Тариалан суманд Бор хавцал, Мээрэн, Бургастай, Өмнөговь сумын орлогын голын нөхөн сэргээсэн талбай, Ховд аймгийн Мөст суманд “Нарийн давын ам”, Цэцэг сумын “Цагаан эрэг”, Үенч сумын “Цагаан чулууын ам” Булган сумын “Цоохор нуур”, Алтай сумын “Халтар уул” нэртэй газруудад 10 хоногийн хугацаанд нийт 729 бичил уурхай эрхлэгч иргэд, сумдын төрийн албан хаагчдад болон хууль бус ашигт малтмал олборлож байгаа иргэдэд бичил уурхайн 308-р журмын хэрэгжилтийн талаар заавар, зөвөлгөө өгч томилолтоор ажиллав.</p>	
<p>7.5. “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын зарчим болон шалгуурыг хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, ил тод байдлыг хангана.</p>			
<p>7.5.1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (ОУИТБС)-ын маягт 5 буюу ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжээс улсын төсөвт төвлөрүүлсэн албан татвар, хураамжийн мэдээллээр холбогдох байгууллагуудыг хангах. ОУИТБС-ын нэгтгэл тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд ОУИТБС-ын зарчим, шалгуур, ач холбогдлыг сурталчлах, тайлбарлан таниулах.</p>	<p>Тоо-шаардлагатай тоо хэмжээгээр Чанар- Үнэн зөв, цаг хугацаандаа багтсан байх Хугацаа: 4-р улиралд</p>	<ul style="list-style-type: none"> - Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2015 оны нэгтгэлийн тайланг бэлтгэх хараат бус хянагч - нэгтгэгчээр томилогдон ажиллаж байгаа Улаанбаатар аудитын газарт улсын болон орон нутгийн төсөвт аж ахуйн нэгжүүдийн төлсөн төлбөрийн задаргааг аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрөл тус бүрээр гаргаж 2016.10.20-ны өдөр хүргүүлсэн. - Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2015 оны нэгтгэлийн тайланг бэлтгэх хараат бус хянагч - нэгтгэгчээр томилогдон ажиллаж байгаа Улаанбаатар аудитын газарт 38 төрлийн мэдээллийг хамрах хэлтэс, нэгжүүдээс гаргуулж нэгтгэн бичгээр болон erdenetsog@ulaanbaatar-audit.mn хаягаар хүргүүлэв. - Санхүүгийн хэлтсээс 2016 онд аж ахуйн нэгжүүдээс төлсөн тусгай зөвшөөрлүүдийн төлбөрийн жагсаалт авч 2016 оны 1 дүгээр сарын төлбөрийг Кадастрын системийн бүртгэлтэй тулгалт хийв. - ОУИТБС-ын ажлын хэсгийн 4 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан хурлаар байгуулагдсан ашиг хүртэгч эздийг ил тод болгох ажлын дэд хэсгийн хуралд оролцов. - ОУИТБС-ын маягт 1, 2-ын дагуу 2016 оны цахим тайланг хэрхэн гаргах талаар гарын авлага бэлтгэж хэлтсийн мэдээллийн самбарт байршуулсан. - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2016 оны цахим тайланг ирүүлэх тухай зарыг уулын ажлын төлөвлөгөө, тайлан цахимаар хүлээж авах цахим хуудсанд байршуулсан. 	

		- Монголын “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын ажлын хэсгийн 42 дугаар хуралдаанд оролцож 2015 оны нэгтгэл тайлангийн төсөлд тайлбар хийв.	
7.8. Эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх санхүүжилтийн асуудлын эрх зүйн орчныг бий болгож, нөхөн сэргээлт хийсэн газрын мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.			
7.8.1. Нөхөн сэргээлт хийгдсэн газрын мэдээллийг нэгдсэн санд нэгтгэх, санг хөтлөх, баяжуулах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах.	Тоо- шаардлагатай тоо хэмжээгээр Чанар- хууль, журмын дагуу Хугацаа: 4-р улиралд	Энэ ажлын хүрээнд: - БОАЖЯ, ХБНГУ-ын байгаль орчны агентлагийн хамтран зохион байгуулсан “Монгол улсын уул уурхайн салбарын нөхөн сэргээлтийн чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт семинарт оролцов. - 2015 онд тайлан ирүүлсэн аж ахуйн нэгж бүрээр нь нөхөн сэргээлтийн хэмжээ болон зардлын судалгааг гаргав. - Олборлох үйлдвэрлэлийн ил тодын тайланг хянан, нэгтгэж байгаа Улаанбаатар аудит ХХК-ийг 2015 онд тайлан ирүүлсэн аж ахуй нэгж бүрээр нь нөхөн сэргээлтийн хэмжээ болон зардлыг гаргаж мэдээллээр хангав. - БОАЖЯ-нд 2015 оны тайлан, 2016 оны төлөвлөгөөгөөр уулын ажилд хамрагдсан талбай, нөхөн сэргээсэн талбай, зардлын мэдээллийг бэлтгэж цахимаар хүргүүлэв.	
7.14. Техник эдийн засгийн үндэслэл			
7.14.1. Уулын үйлдвэр, уурхайн Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг хүлээн авах, бүртгэх, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдааныг зохион байгуулах. - 2016 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж, хүлээн авах ТЭЗҮ-ээс ашигт малтмалын нөөц, олборлолт, баяжуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчин, хүний нөөц, эдийн засаг, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн талаарх мэдээллийг авч, мэдээллийн санд нэгтгэх. - Геологийн мэдээллийн төв архивт байгаа ТЭЗҮ-ээс ашигт малтмалын нөөц, олборлолт, баяжуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчин, хүний нөөц, эдийн засаг, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн талаарх мэдээллийг авч, мэдээллийн санд нэгтгэх.	Тоо-1 санал, 1 судалгаа Чанар- Цаашид авах арга хэмжээний цогц саналтай болсон байна. Хугацаа: 4-р улиралд	- ЭБЭХ-ны Сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дугаар 074 тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу боловсруулан 2016 онд ирсэн 110 Техник-эдийн засгийн үндэслэлд шинжээч томилуулж, 104 танилцах хуудас олгож, мөн тооны металл болон металл бус ашигт малтмал ашиглах төсөлтэй танилцсан байна. а) Ирүүлсэн төслүүдийг ЭБМЗ-ийн хурлаар (2016.10.17-ны өдрийн байдлаар) 136 (давхардсан тоогоор) Техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцүүлэх бэлтгэл ханган, хурлын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаа. Үүнээс хүлээн авсан 57, ажлын шугамаар хүлээн авсан 74, ЭБМЗ-өөр хэлэлцүүлж дахин хэлэлцүүлэхээр буцаасан 5 төсөл байна. 2016 онд Техник эдийн засгийн үндэслэл боловсруулж танилцуулах, хэлэлцүүлэх шатандаа яваа 15 төсөл байна.	

<p>- Техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлагын дагуу төслүүдийг үнэлж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах.</p>		<p>б) 2016 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаан 15 удаа, өргөтгөсөн хуралдаан 3 удаа зохион байгуулж хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлсөн байна.</p> <p>в) Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 125 дүгнэлт, АМГ-ын даргын тушаал гаргажээ.</p> <p>г) Хүлээн авсан техник, эдийн засгийн үндэслэлийн 76 товч танилцуулгыг файл аар авсан байна. Эдийн засгийн хувьд үр ашигтай ашигт малтмалын алтны шороон ордын дэлгэрэнгүй судалгааг 4 ордод хийсэн байна.</p> <p>- 2016 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж, хүлээн авсан бүх ТЭЗҮ-ийн ашигт малтмалын нөөц, олборлолт, баяжуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчин, хүний нөөц, эдийн засаг, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн талаарх мэдээллийг авч, мэдээллийн санд нэгтгэв.</p> <p>- 2016 онд хүлээн авсан алтны томоохон шороон ордын ТЭЗҮ-ийн мэдээлэлд тулгуурлан мэдээлэл авч баяжуулах ажлын хүрээнд 10 төслийн мэдээллийг 56 үзүүлэлтээр нэгтгэв.</p> <p>- ЭБМЗ-ийн дүрэмд өөрчлөлт оруулах талаар, “Шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлал”-д шинээр 2015 оны 03 дугаар сард УУЯ-ны ахлах мэргэжилтэн Д.Алтанхуягт санал өгөв.</p> <p>ЭБМЗ-ийн дүрмийн 3 дугаар хавсралтаар баталсан “Шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлал”-тай танилцан санал боловсруулан ТЭЗҮ-ийн салбар хуралдааны дарга И.Болдод хүргүүлэв.</p>	
<p>7.18. Стратегийн ач холбогдол бүхий ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг эрчимжүүлэх.</p>			
<p>7.18.1. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын мэдээллийг шинэчлэх. Холбогдох байгууллага, ажлын хэсгийн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын мэдээллээр хангах.</p>	<p>Тоо-1 судалгаа Чанар- Шинэ жагсаалт гархуйц чанартай шуурхай байх. Хугацаа: 4-р улиралд</p>	<p>Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын талаарх мэдээллийг шинэчлэн боловсруулж байна.</p> <p>“Оюу толгой” ХХК-д 2016.12.02 өдрийн 5/22-09 албан бичгээр хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилт, далд уурхайн бүтээн байгуулалтын явцын талаар мэдээлэл ирүүлэх хүсэлт тавьж мэдээллийн санг баяжуулав.</p> <p>Гацуурт, Оюутолгойн ордуудын мэдээллийг Уул уурхайн яам болон Ажлын хэсгийн хүсэлтээр гаргаж өгсөн.</p>	
<p>Найм. "Хүнд үйлдвэрийн салбарын хөгжлийн бодлого боловсруулах, дэмжлэг үзүүлэн шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах, инновацын идэвхижилтийн судалгааг хийх" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:</p>			
<p>8.6. Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.</p>			
<p>8.6.1. Говийн бүсэд жилд 2,0 сая тонн</p>	<p>Тоо- 1 судалгаа, 1 санал</p>	<p>Говийн бүсэд жилд 2,0 сая тонн хүртэлх газрын тос</p>	

<p>хүртлэх газрын тос боловсруулах үйлдвэрийн ажлын хэсэгт орж ажиллах, мэдээллээр хангах, судалгааг хийх.</p> <p>- Түүхий тос дамжуулах хоолой барих ажлын хэсэгт орж ажиллах, мэдээллээр хангах, судлагааг хийх.</p> <p>- Зүүн бүсэд жилд 300,0 мянган тонн хүртэлх газрын тос боловсруулах үйлдвэр барих ажлын хэсэгт орж ажиллах.</p> <p>Хийгдсэн судалгаануудыг боловсронгуй болгох</p>	<p>Чанар- Үндэслэл сайтай Хугацаа: 4-р улиралд</p>	<p>боловсруулах үйлдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсэгт оролцон ажиллах, санал боловсруулах талаар судалгааны ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Түүхий тос дамжуулах хоолой барих ажлын хэсэгт оролцох, санал боловсруулах, мэдээллээр хангах ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Зүүн бүсэд жилд 300,0 мянган тонн хүртэл газрын тос боловсруулах үйлдвэр барих ажлын хэсэгт оролцон ажиллах, санал боловсруулах, мэдээллээр хангах ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Хийгдсэн судалгаануудыг боловсруулах ажил хийгдэж байна.</p>	
<p>8.14. Эрдэс баялгийг боловсруулах, борлуулах үйл ажиллагааны эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, дунд болон урт хугацааны хөтөлбөр боловсруулах.</p>			
<p>8.14.1. “Алт хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллан үр дүнг УУХҮ-ийн сайдын зөвлөлд танилцуулах.</p> <p>“Хайлуур жонш хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллан үр дүнг УУХҮ-ийн сайдын зөвлөлд танилцуулах.</p> <p>“Цайр ба бусад холимог металл хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллан үр дүнг УУХҮ-ийн сайдын зөвлөлд танилцуулах.</p> <p>“Газрын ховор элемент хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллан үр дүнг УУХҮ-ийн сайдын зөвлөлд танилцуулах</p> <p>“Нүүрс хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллан үр дүнг УУХҮ-ийн сайдын зөвлөлд танилцуулах</p>	<p>Тоо- шаардлагатай тоо хэмжээгээр Чанар- хууль, журмын дагуу, хүртээмжтэй Хугацаа: 4-р улиралд</p>	<p>“Алт хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллан үр дүнг сайдын зөвлөлд танилцуулахаар ажиллаж байна.</p> <p>“Хайлуур жонш хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллан үр дүнг Сайдын зөвлөлд танилцуулахаар ажиллаж байна.</p> <p>“Цайр ба бусад холимог металл хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллан, үр дүнг Сайдын зөвлөлд танилцуулахаар ажиллаж байна.</p> <p>“Газрын ховор элемент хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллан, үр дүнг сайдын зөвлөлд танилцуулахаар ажиллаж байна.</p> <p>“Нүүрс хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэгт орж ажиллан, үр дүнг сайдын зөвлөлд танилцуулахаар ажиллаж байна.</p>	
<p>8.21. Боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулах</p>			
<p>8.21.1. Боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулагчдад хууль эрх зүйн болон дэд бүтцийн таатай орчин бүрдүүлэх замаар томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг улсын болон бүс нутгийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулан шийдвэрлэх;</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн</p>	<p>Тоо- 1 санал, 2 арга хэмжээ Чанар- Үндэслэл сайтай, хэрэгжихүйц бодитой Хугацаа: 3,4-р улиралд</p>	<p>Боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулагчдад хууль эрх зүйн болон дэд бүтцийн таатай орчин бүрдүүлэх замаар томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг улсын болон бүс нутгийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулан шийдвэрлэхэд шаардагдах материалуудыг цуглуулах, судлах, боловсруулах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Мөн уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн цогцолборыг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр</p>	

цогцолборыг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх		шаардагдах материалуудыг цуглуулах, судлах, боловсруулах ажлыг зохион байгуулж байна.	
8.23. Инноваци, өндөр технологийн талаар судалгаа хийж өөрийн орны нөхцөлд нэвтрүүлэх			
8.23.1. Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт техник технологи судлах, танилцуулах, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах	Тоо- 1 санал, 2 арга хэмжээ Чанар- Үндэслэл сайтай, хэрэгжихүйц бодитой Хугацаа: 3,4-р улиралд	Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт техник технологи судлах, танилцуулах, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах судалгааны ажлыг эхлүүлээд байна.	
8.23.2. Нүүрс, газрын тос боловсруулалтыг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт техник технологи танилцуулах, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах		Нүүрс, газрын тос боловсруулалтыг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт техник технологи танилцуулах, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах судалгааны ажлыг эхлүүлээд байна.	
Арав. “Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ердийн болон цацраг идэвхит ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газрын тосны эрэл, хайгуулын болон гэрээт талбайд холбогдох кадастрын үйлчилгээ үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтын хүрээнд:			
10.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүсэх, хугацааг нь сунгах, барьцаалах, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг буцааж хүлээлгэн өгөх өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх			
10.1.1. Төрөөс тогтоосон талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдлийг хүлээн авч бүртгэн, хянан шийдвэрлэж, тусгай зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулах	Тоо хэмжээ-1 ажил үйлчилгээ Хугацаа-тогтмол Чанар-Хуульд нийцсэн байх	Төрөөс тогтоосон талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл авахыг хүссэн 113 өргөдөлд Засаг даргын санал авах мэдэгдлийн төслийг боловсруулж, хянуулан шийдвэрлэсэн. Зураг зүйн шүүлтээр хуулиар хориглосон газартай давхцалтай 43 өргөдлийг бүртгэлээс хасах шийдвэр мэдэгдлийн төсөл боловсруулж хянуулан шийдвэрлүүлсэн. Засаг даргын саналыг үндэслэн 45 өргөдлийг бүртгэлээс хасах шийдвэр мэдэгдлийн төсөл боловсруулж, хянуулан шийдвэрлүүлсэн. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох 624 шийдвэр мэдэгдлийн төсөл боловсруулж, хянуулан шийдвэрлүүлсэн. Ашигт малтмалын хайгуулын 517 тусгай зөвшөөрлийг шинээр олгож шийдвэрлэлээ. Шүүхийн шийдвэрийн дагуу ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 2 нэмэлт өргөдлийг хүлээн авч, бүртгэн, хянуулж байна.	
10.1.2. Аж ахуйн нэгж, байгууллагаас ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч бүртгэх, хянан шийдвэрлэж, тусгай зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулах	Тоо хэмжээ-1 ажил үйлчилгээ Хугацаа-тогтмол Чанар-Хуульд нийцсэн байх	Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн 85 өргөдлийг хүлээн авч УУККС-д бүртгэн, шийдвэр, мэдэгдлийн төслийг боловсруулан холбогдох мэргэжилтнүүдээр хянуулж, 79 өргөдлийг ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлүүлэв. 2011-2015 онд хүлээн авсан шийдвэрлэгдээгүй ашиглалтын	

		тусгай зөвшөөрөл хүссэн 12 өргөдөлд олгохоос татгалзах төсөл боловсруулан хянуулж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан 5 өргөдлийн шийдвэрийн дагуух мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шуудангаар хүргүүлсэн.	
10.1.4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн материалыг хүлээн авч бүртгэн, холбогдох дүгнэлтийн төсөл боловсруулан, хүргүүлэх.	Тоо хэмжээ-1 ажил үйлчилгээ Хугацаа-тогтмол Чанар-Хуульд нийцсэн байх	Түгээмэл тархацтай ашигт малтмалын /ТТАМ/ хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 193 өргөдлийг хүлээн авч бүртгэн ЭБМТТөвөөр шүүлт хийлгэн дүгнэлтийн төсөл боловсруулан хянуулж, орон нутагт шуудангаар хүргүүлэв. ТТАМ-ын тусгай зөвшөөрөлтэй холбоотой орон нутгийн шийдвэр гаргасан 105 тусгай зөвшөөрлийг тухай бүрт шийдвэрийг УУККС-д бүртгэв. АМТХ болон “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын дагуу орон нутгаас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох 66 нөхөрлөлийн материалыг шалгаж зураг зүйн болон ЭБМТТөвөөр шүүлт хийлгэн, дүгнэлтийн төсөл боловсруулан хянуулж хүргүүлэн, бүртгэлийг хөтөлсөн. Нийслэл, 21 аймгийн түгээмэл тархацтай ашигт малтмал хариуцсан хэлтэс, албанд зөвлөмж, тодруулга хүргүүлэв.	
10.1.7. Өргөдлөөр хүсэлт гаргасан талбайд зураг зүйн шүүлт хийх	Тоо хэмжээ-1 ажил үйлчилгээ Хугацаа- тогтмол Чанар-Хуульд нийцсэн байх	Ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр авахыг хүссэн 85, тусгай зөвшөөрлөө сунгуулахыг хүссэн 157, тусгай зөвшөөрлөө барьцаалахыг хүссэн 24, талбайгаа хэсэгчлэн болон бүхэлд нь буцаахыг хүссэн 124, тусгай зөвшөөрлөө шилжүүлэхийг хүссэн 131, тусгай зөвшөөрлөө нөхөж авахыг хүссэн 33, ТТАМ-ын тусгай зөвшөөрөл хүссэн 193 өргөдөлд зураг зүйн мэдээллийн санд тулгуурлан шүүлт хийв.	
10.1.8 Сонгон шалгаруулалтын журмаар олгох боломжтой талбайг багцалж, бэлтгэл ажлыг ханган, нийтэд зарлаж, сонгон шалгаруулалтын саналыг хүлээн авч бүртгэн, шийдвэрлэн, тусгай зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулах	Тоо хэмжээ-1 ажил үйлчилгээ Хугацаа- Цаг тухайд нь Чанар-Хууль, журамд нийцүүлэн	- Сонгон шалгаруулалт зарлах 10 багц 574932 га бүхий 97 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой 346 талбайн орших орон нутгийн Засаг дарга нарт санал авах мэдэгдлийг талбайн зургийн хамт шуудангаар хүргүүлсэн. - Сонгон шалгаруулалтаар 351597 га бүхий 37 талбайд буюу нийт зарлагдсан талбайн 65 хувьд нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон. Хайгуулын тусгай зөвшөөрөл Сонгон шалгаруулалтаар олгох үйл ажиллагаанаас улсын төсөвт нийт 10 тэрбум 152 сая төгрөг төвлөрүүлээд байна.	

		- Шинээр төрөөс тогтоож, сонгон шалгаруулалтаар олгох талбайнуудыг бэлтгэж ЭБМТХ-т хүлээлгэн өгсөн. /Нийт 196 полигон файл, 30900 солбицлыг боловсруулсан/	
Арван хоёр. “Газрын тосны бүтээгдэхүүн, шатах ашигт малтмал болон тэдгээрийн бүтээгдэхүүний шинжилгээ, туршилтыг Монгол улсад мөрдөгдөж буй стандартын дагуу чанарын өндөр төвшинд, хурдан шуурхай гүйцэтгэх, дүгнэлт гаргах, санал зөвлөмж боловсруулах, ашигт малтмалын салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:			
12.2. Улаанбаатар хот дахь газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын лабораторид итгэмжлэл авах.			
12.2.1. Улаанбаатар хот дахь чанарын хяналтын лабораторид итгэмжлэл авах ажлын хүрээнд мөрдөгдөх бичиг баримтанд урьдчилсан үзлэг хийлгүүлж, итгэмжлэлийн гэрчилгээ авах Улаанбаатар хот дахь газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын лабораторид итгэмжлэл авах ажлыг зохион байгуулан ажиллах	Тоо хэмжээ: 1 ажил Хугацаа: 3-4 улиралд Улаанбаатар хот дахь газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын лабораторид итгэмжлэл авах ажлыг зохион байгуулан ажилласан байна.	Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/70 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавигдах шаардлага” MNS ISO/IEC 17025:2007 стандартын шаардлагын дагуу газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын лаборатори /хуучин нэрээр/-ийг шалгаж 9 үл тохирол, 3 зөвлөмжийг илрүүлсэн ба 3 сарын хугацаанд хийх хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Тус үл тохирол, зөвлөмжүүдийн биелэлтийг гаргаж 2016 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 1/562 тоот албан бичгээр СХЗГ-т хүргүүлсэн. - СХЗГ-ын Итгэмжлэлийн техникийн хорооны хурал товлогдож хуралдахыг хүлээж байна. Тус хурлын шийдвэрээр итгэмжлэлийг олгоно.	
Тусгай арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО			

ГУРАВ. МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ:

<i>Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц), түүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин</i>	<i>Жинхэнэ гүйцэтгэл (шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин)</i>	<i>Үнэлгээ (0-30 оноо)</i>	
1	2	3	
1. Байгууллагын ил тод байдлыг хангах талаар: Төрийн албаны нээлттэй ил тод байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах а) Агентлагийн албан ёсны цахим хуудсыг шинэчлэх, цаг үеийн шаардлагатай мэдээ мэдээллийг байршуулах ажлыг зохион байгуулах	- Байгууллагын веб хуудсанд шаардлагатай мэдээ мэдээлэл, шинээр гарсан болон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм журам, зааврыг шуурхай байрлуулсан иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүргэж байна. - Байгууллагын болон кадастрын веб сайтын хэвийн үйл ажиллагааг хангаж шаардлагатай мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь тогтмол шинэчилж ажилласан. Нийт 186 мэдээ байршуулсан байна. Байгууллагын веб сайтын загвар дизайныг шинэчлэх ажлыг		

<p>б) Агентлагийн болон салбарын үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлаар дамжуулан дэлгэрүүлж таниулах, “Ил тод уул уурхай” арга хэмжээнд мэдээлэл бэлтгэн оролцох</p> <p>в) Үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авах</p>	<p>үргэлжлүүлэн, мэргэжлийн компанитай хамтран динамик төвшний веб хуудсыг сайжруулан хийхээр ажиллаж байна.</p> <p>Байгууллагын болон салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тогтмол оруулан ажилласан.</p> <p>Байгууллагын веб хуудасны шинэчилсэн хувилбарыг туршилтын журмаар www.mrpam.gov.mn/mrpam/ хаягаар ажиллуулж байна.</p> <p>- Сар бүрийн сүүлийн долоо хоногийн Лхагва гарагийн “Ил тод уул уурхай” хэвлэлийн бага хуралд мэдээлэл бэлтгэж, Уул уурхайн яаманд цаг тухайд нь Монгол, Англи хэл дээр хүргүүлж ажилласан. 2016 оны эхний хагас жилд 5 удаагийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулахад хамтарч ажиллав.</p> <p>- Газрын тосны салбарын хэмжээн дэх мэдээ мэдээлэл болон байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд түгээн сурталчлах “Газрын тосны салбар-2016” нэгдсэн төлөвлөгөө боловсруулан олон нийтэд мэдээлэн сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулж ажилласан.</p> <p>Төлөвлөгөөний дагуу газрын тосны салбарын үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв үйл ажиллагааны үр дүнг МҮОНРТ, Eagle, UBS, TV-5, MNC, Bloomberg, NTV, ТМ, TV-25 дугаар суваг орон нутгийн телевиз болон 3 вэб сайт, 6 өдөр тутмын сонин, 1 радиогоор дамжуулан хэвлэлийн 120 мэдээ бэлтгэн олон нийтэд хүргэсэн.</p> <p>Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдэд нийтлэгдсэн мэдээ, мэдээллийн 16%-ийг газрын үйл ажиллагаатай холбоотой, 18,6% нь газрын тосны олборлолттой холбоотой, газрын тосны бүтээгдэхүүний хангамж үнэ болон нүүрсний үнэтэй холбоотой мэдээлэл 51,4%-ийг, үлдсэн 20%-ийг бусад мэдээлэл эзэлж байна.</p> <p>- Статистик мэдээллийн тохимолыг УУХҮЯ, УИХ-ын байнгын хороод, ЗГХЭГ, ЕТГ, ҮАБЗАА болон байгууллагын алба, хэлтэс бүрд сар болгон хүргүүлж, нийтэд зориулж байгууллагын вэб хуудсанд тавьж хэвшсэн.</p>		
<p>2. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар:</p> <p>Төсвийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, байгууллагын төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p>а) Агентлагийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан санхүүгийн тайлан балансыг нийтэд ил тод танилцуулах, “Шилэн данс”-ны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах</p>	<p>Байгууллагын аудитлагдсан санхүүгийн тайлан балансыг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод танилцуулж байна.</p> <p>Мөн энэ ажлын хүрээнд санхүүгийн шинэ програм хангамж ашиглаж эхэлснээр интернэтийн орчинд санхүүгийн тайлан мэдээг боловсруулан гаргах, холбогдох байгууллагуудад тайлагнах боломжтой болсон.</p> <p>- 2 агентлагийг нэгтгэснээр 2016 оны 7 дугаар сарын 31-ны өдрөөр хаалтын санхүүгийн тайлан, 8 дугаар сарын 1-ний өдрөөр нээлтийн балансыг гаргаж, УУХҮЯ-нд хүргүүлсэн. 2 агентлагийн хаалтын баланс, санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас санхүүгийн шалгалт хийгдэж байна.</p> <p>- “Шилэн данс”-ны тухай хууль хэрэгжиж эхэлсний дагуу шилэн дансны</p>		

	<p>цахим хуудсанд 5,0 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого зарлагын гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагуудтай хийсэн гэрээ болон бусад холбогдох мэдээллийг тогтмол байршуулан ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. - Үндэсний аудитын газраас Уул уурхайн сайдын багцын хүрээнд, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын шалгалтад хамрагдаж Зөрчилгүй сайн гэсэн дүгнэлт авав. - Байгууллагын веб хуудсанд “шилэн данс” цэсийг ажиллуулан дээрх мэдээллийг тогтмол оруулж байна. 		
<p>3.Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар:</p> <p>Батлагдсан төсвийн хүрээнд үр ашигтай санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллах</p> <p>а) Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын хөрөнгийн чадавхийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах</p> <p>б) Өмч хамгаалах зөвлөлтэй хамтран хугацаа дууссан хөрөнгүүдийг актлуулах, хөрөнгийн бүртгэлээс хасуулах асуудлыг шийдвэрлүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа автомашинуудын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан тасралтгүй, найдвартай ажиллагааг ханган ажилласан. - Тээврийн хэрэгслийн улсын үзлэг тооллогод нийт автомашинуудыг хамруулан тэнцүүлж, татвар хураамжийг төлөх, даатгал хийлгэх ажлыг зохион байгуулсан. - Байгууллагын конторын байрны засвар үйлчилгээ, харуул хамгаалалт, харилцаа холбооны техник хэрэгслийн ашиглалтад хяналт тавин, хариуцан ажилласан. - Байгууллагын конторын байрны засвар үйлчилгээ, засвар хийгдэх шаардлагатай өрөөнүүдийн санал, төсвийг боловсруулан ЗГ-ын байр ашиглалтын нэгдсэн захиргаанд хүргүүлэн, засваруудыг хийж гүйцэтгэсэн. - АМГТГ-ын даргын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн а/29 дүгээр тушаалаар байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг, а/30 дугаар тушаалаар техникийн комиссыг шинэчлэн баталж, шуурхай тогтмол ажиллагааг хангасан. - АМГТГ-ын даргын 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А-41 дүгээр тушаалаар 2016 оны үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийх ажлын хэсгийг тушаалаар баталсан бөгөөд тооллогын ажлыг хийж гүйцэтгэж байна. 		
<p>4.Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар:</p> <p>Сургалтын хөтөлбөрийн дагуу ажилтан албан хаагчдын сургалт, давтан сургалтыг зохион байгуулан ажиллах</p> <p>а) Төрийн албаны тухай хууль болон бусад хууль</p>	<p>Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдсэнтэй холбогдуулан нийт албан хаагчдын цалин, ур чадвар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг хууль журманд нийцүүлэн боловсруулж, тушаалаар батлан мөрдүүлсэн. <p>Хүний нөөцтэй холбогдолтой нийт 138 тушаал батлагдсан байна.</p> <ul style="list-style-type: none"> - Батлагдсан орон тооны дагуу нийт ажлын байрны тодорхойлолтод 		

<p>тогтоомжид нийцүүлэн байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг батлан, байгууллагыг чадварлаг мэргэшсэн албан хаагчдаар хангах</p> <p>б) Батлагдсан төсвийн хүрээнд 2016 онд зохион байгуулагдах богино, дунд, урт хугацааны сургалтуудыг зохион байгуулан ажиллах</p> <p>в) Ажилтан албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт, давтан сургалтыг зохион байгуулах, санхүүжүүлэх нэмэлт эх үүсвэр эрэлхийлэн ажиллах</p>	<p>тухайн албан тушаалын ажлыг тодорхой зааж, ажлын давхардлыг арилган, ажлын ачааллыг жигдрүүлэн нарийвчлан боловсруулж, баталсан.</p> <p>- Төрийн албан хаагчийн зэрэг дэв ахиулах, шинээр олгуулахаар 28 албан хаагчийн материалыг бүрдүүлэн, II сард багтаан УУЯ-ны дэргэдэх ТАЗ-ийн салбар зөвлөлд хүргүүлсэн. 2016 оны III сард зохион байгуулагдсан УУЯ-ны дэргэдэх ТАЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн баталж, ирүүлсэн болно.</p> <p>- Тус газартай “Урт хугацааны сургалтын гэрээ” байгуулан 2015-2016 оны хичээлийн жилд гадаадын их дээд сургуульд суралцсан 88 оюутнаас 20 оюутан сургуулиа төгсөж, шинээр 8 оюутан сургалтын гэрээ байгуулан, өнөөдрийн байдлаар 71 оюутан гадаадын их дээд сургуульд суралцаж байна. Эдгээр суралцагсдын 29 оюутны сургалтын төлбөрийн тодорхой хувийг шийдвэрлэсэн.</p> <p>- “АМГТГ-ын ажиллагсдын сургалтын журам” болон “Урт хугацааны сургалтын гэрээ”-ний загваруудыг шинэчлэн боловсруулж батлуулахад бэлтгэсэн. УУХҮЯ-наас санал авахаар хүргүүлээд байна.</p> <p>- Удирдлагын Академийн Мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран зохион байгуулж буй байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан “Байгууллагын менежментийн хөгжлийн чиг хандлага” сэдэвт 68 цагийн багц сургалтыг зохион байгуулж байна.</p> <p>- 2016 оны сүүлийн хагас жилд дотоодын магистрт 1 ажилтан, Японы ЖАЙКА, БНСУ-ын КОЙКА-ийн сургалтад тус бүр 1 ажилтан, БНСУ-ын КИГАМ-ын сургалтад 2 мэргэжилтэнг хамруулсан.</p> <p>- 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Архивын ерөнхий газрын Мэргэжил, аргазүйн газрын дарга Ц.Цэндсүрэнг урин ирүүлж “Албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалт” сэдвээр нийт ажилтан, албан хаагчдын дунд сургалт зохион байгуулав.</p>		
<p>Манлайллын зорилтын биелэлтийн ДУНДАЖ ОНОО</p>			

Тайлан бичсэн: Төсвийн шууд захирагч:

Ашигт малтмал, газрын тосны газрын дарга /Б.Баатарцогт/

2016 оны 12-р сарын 15-ны өдөр